



Нээлтэй
Нийгэм
Форум

ШҮҮХ ХУРАЛДААНЫ АЖИГЛАЛТЫН ТАЙЛАН

2010.4.05 - 2010.6.25



Нээлтэй
Нийгэм
Форум

ШҮҮХ ХУРАЛДААНЫ АЖИГЛАЛТЫН ТАЙЛАН

Тайланг эмхэтгэж редакторласан:

П. Бадамрагчаа

Ц. Одончимэг

Тайлан бичсэн:

Н. Туяа

М. Ариунаа

Р. Оюунбадам

С. Мойлтмаа

© Нээлтэй Нийгэм Форум

Тайланг хувийн хэрэгцээнээс бусад зорилгоор хэсэгчлэн болон бүтнээр нь хувилж олшруулахыг хүсвэл доорх хаягаар хандаж зохих зөвшөөрөл авна уу.

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Жамъян гүний гудамж - 5/1

Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар - 48,

Монгол Улс

Утас: 976-11-313207

Факс: 976-11-324857

Вэб: <http://www.forum.mn>

И-мэйл: osf@forum.mn

Гарчиг

НЭГ. УДИРТГАЛ

1.1. Төслийг хэрэгжүүлэх шаардлага.....	6
1.2. Төслийн зорилго, ач холбогдол	6
1.3. Ажиглалтын арга зүй	6
1.4. Ажиглалтын чиглэл.....	7
1.5. Төслийн хамрах хүрээ	8

ХОЁР. ШҮҮХ ХУРАЛДААНЫ АЖИГЛАЛТЫН ДҮН

2.1. Шударга шүүхийн стандарт хангагдсан байдал.....	9
2.1.1. Нээлттэй шүүх хуралдаанаар хэргээ хэлэлцүүлэх эрх	9
2.1.2. Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх эрх.....	11
2.1.3. Шүүгч шүүх хуралдаанд оролцогчдын эрхийг тайлбарлаж, ойлгуулсан эсэх талаар ...	14
2.1.4. Оролцогчид шүүх хуралдааны явцад хуулиар өөрт нь олгогдсон боломжоор хангагдаж байсан эсэх талаар.....	21
2.2. Шүүх хуралдаанд оролцогчдын оролцоо	24
2.2.1. Шүүгч	24
2.2.2. Улсын яллагч	26
2.2.3. Өмгөөлөгч	28
2.2.4. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга	30
2.2.5. Орчуулагч, хэлмэрч	32
2.2.6. Хохирогч	34
2.2.7. Гэрч	35
2.2.8. Иргэдийн төлөөлөгч.....	36
2.3. Шүүхийн цаг барилт, дэг журам хангагдаж буй байдал	38
2.3.1. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явагдсан хугацаа	38
2.3.2. Шүүх хуралдаан товлосон цагтаа эхэлж буй байдал	42
2.3.3. Шүүх хуралдаан хойшилсон эсэх, хойшилсон шалтгаан	44
2.3.4. Шүүхэд хэв журам, аюулгүй байдлыг хангаж буй байдал	48

2.4. Шүүхийн байрны нөхцөл байдал.....	54
2.4.1. Шүүхийн байршил.....	54
2.4.2. Шүүх иргэдэд шаардлагатай мэдээллийг зохих хэлбэрээр хүргэж буй байдал	56
2.4.3. Шүүхийн байр, шүүх хуралдааны танхимын зай хэмжээ, багтаамж, хүртээмжтэй байдал	58
2.4.4. Шүүхийн байр, шүүх хуралдааны танхимын хүндэтгэл төрүүлэхүйц, цэвэр тохилог байдал	64

ГУРАВ. ХАВСРАЛТ

Шүүх хуралдааны ажиглалтын тухай ойлголт	67
Шударга шүүхийн тухай ойлголт	69
Шүүх хуралдааны ажиглалтын хуудас	74
“Шүүхийн ажиглалт” – төсөлд оролцсон ажиглагчдын нэрс.....	80
Төслийн баг:	81

Өмнөх үг

Нээлттэй Нийгэм Форум 2008 оноос эхлэн шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх үйл явцад дүн шинжилгээ хийх, шүүхийн шинэтгэлийн асуудлаар бүхий л талуудын оролцоотой мэдээлэл судалгаан дээр тулгуурласан ажил хэрэгч харилцан яриа хэлэлцүүлэг өрнүүлэхийг эрмэлзэж, шүүхийн үйл ажиллагааны ил тод, хараат бус байдалд хөндлөнгийн мониторинг, ажиглалт хийж ирлээ. 2010 онд Нээлттэй Нийгэм Форум нь Отгонтэнгэр Их Сургуулийн Хууль Зүйн Сургууль, Монгол Улсын Их Сургуулийн Хууль Зүйн Сургууль болон Шихихутаг Хууль Зүйн Дээд Сургуультай хамтран “Шүүх хуралдааны ажиглалт” төсөл хэрэгжүүлсний үр дүнг энэхүү тайлангаар хүргэж байна. Нийт 30 оюутан, 9 иргэний нийгмийн төлөөлөл гурван сарын туршид 287 шүүх хурлын ажиллагааг ажиглаж шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй, иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй эсэх, шүүхийн ажилтнуудын зан харилцаа, шүүхийн байрны нөхцөл байдал зэрэгт үнэлэлт дүгнэлт өглөө.

Олон улсын туршлагаас харахад шүүхийн үйл ажиллагаанд олон нийт, иргэний нийгмийн зүгээс ажиглалт, мониторинг хийх нь шүүхийн ил тод, хараат бус, үр дүнтэй байдлыг дээшлүүлэхэд чухал хөшүүрэг болдог бөгөөд олон оронд байнгын үйл ажиллагаа болон хэвшжээ. Ийм ажиглалт хийдэг олон арга хэлбэрийг харьцуулан судалсны үндсэн дээр бид манай нөхцөлд илүү тохиромжтой арга зүйг боловсруулсан бөгөөд цаашид иргэний нийгмийн байгууллагууд болон хууль зүйн эрдэмтэд, судлаачид, оюутан сурагчид өргөн хэрэглэхүйц арга хэрэгсэл болгох чиглэлээр сайжруулж байгаа тул Та бүхний үнэтэй санал зөвлөмжийг хүлээн авахдаа таатай байх болно.

Шүүхийн шинэтгэлийг гүнзгийрүүлэхэд энэхүү баримтжуулсан мэдээлэл, түүн дээр үндэслэсэн зөвлөмж нь энэхүү шинэтгэлийг гардан гүйцэтгэгч хуульч Та бүхний ажил хэрэгт бага ч гэсэн хувь нэмэр болох болов уу хэмээн найдаж байна.

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал
П.Эрдэнэжаргал

1.1. Төслийг хэрэгжүүлэх шаардлага

1992 оны Монгол Улсын Үндсэн хууль болон 1993 онд батлагдсан Шүүхийн тухай хуулиар шүүхийн болон шүүгчийн бие даасан, хараат бус байдлыг баталгаажуулсан билээ. Ийнхүү хууль хэрэгжиж эхэлснээс хойш болон ер нь сүүлийн жилүүдэд “шүүх улс төрийн болон бизнесийн нөлөөнд автсан” хэмээн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нэлээдгүй бичиж, иргэдийн шүүхэд итгэх байдал буурсаар байна. Иймээс шүүхийн шударга, иргэдэд алагчлалгүй, тэгш хандах зарчим хэрэгжиж буй эсэхэд шийдвэр гаргагчдын анхаарлыг хандуулах үүднээс Нээлттэй Нийгэм Форум шүүх хуралдааны ажиглалт төслийг хэрэгжүүллээ.

1.2. Төслийн зорилго, ач холбогдол

Төсөл нь шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлыг хангах, үйл ажиллагаагаа явуулахад нь дэмжлэг болох, олон нийтийн шүүхэд, шүүгчдэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг ил тод болгох, эрх зүйт ёсыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой билээ.

Энэхүү төслийн хүрээнд шүүн таслах ажиллагаа олон улсын хүний эрхийн гэрээ конвенцид баталгаажсан шударга шүүхийн стандартыг дагаж мөрдөж буй эсэхийг тодорхойлж, учирч буй хүндрэл бэрхшээлийг тогтоохыг зорилоо.

Төслийн явцад шүүх хуралдааны ажиглалтын олон улсын жишиг арга зүйг Монголын нөхцөлд туршин хууль зүйн клиник сургалтад шүүх хуралдааны ажиглалтыг нэвтрүүлэх боломж бий болгохыг зорьсон нь хууль зүйн их, дээд сургуульд суралцаж буй оюутнуудад мэргэжлийн зөв хандлага бий болгоход ач тустай юм.

Олон улсын практикаас харахад шүүхийн ажиглалтын арга зүйг ашигласнаар иргэд болон хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн байгууллагууд шүүхийн үйл ажиллагааны талаар бодит мэдээлэлтэй болж, улмаар олон нийтийн шүүхэд итгэх итгэл нэмэгдэж байжээ.

1.3. Ажиглалтын арга зүй

“Шүүх хуралдааны ажиглалт”-ын арга зүйг Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагын¹ “Шүүхийн мониторинг” хөтөлбөрийн зөвлөх Лукаш Боярский

¹ Organization of European Cooperation and Security

тусламжтайгаар манайтай нийгэм, эдийн засгийн хувьд адил түвшний улсуудад хэрэгжүүлсэн туршлагад үндэслэн Монгол Улсын нөхцөл байдалд тохируулан боловсруулсан болно.

Чингэхдээ ажиглалтыг шүүгч, шүүхийн ажилтнуудад албан ёсоор мэдэгдэлгүйгээр хэрэгжүүлэх арга зүйг сонгосон бөгөөд энэ нь мэдээллийн үнэн бодитой байдлыг илүү хангах болно гэж үзлээ.

2006-2007 онд АНУ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс Отгонтэнгэр Их Сургуулийн Хууль Зүйн сургуультай хамтран “Шүүхийн ажиглалт” төслийг хэрэгжүүлсэн нь цар хүрээний хувьд бага хэдий ч шүүхийн мэдээллийг нээлттэй болгоход тус дөхөм болжээ. Тиймээс энэ төслийн үр дүнг баталгаажуулах, мониторинг хийх боломжийг давхар авч үзлээ.

Ажиглалт хийхээр болсон 9 шүүхэд ажиглагчийг сонгохдоо хууль зүйн клиник сургалтын хувьд тогтворжсон, цаашид шүүх хуралдааны ажиглалтын арга зүйг сургалтад нэвтрүүлэх сонирхол бүхий 3 сургуулиас тус бүр 10 оюутныг дараах шалгуурт үндэслэн авч ажиллууллаа. Үүнд:

- хууль зүйн клиник төвд хичээллэдэг,
- эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн хичээлийг бүрэн үзсэн,
- хичээлийн үнэлгээ “В”-ээс дээш,
- цаашид эрүүгийн эрх зүйн чиглэлээр мэргэшиж ажиллах сонирхолтой.

Орон нутагт ажиллах ажиглагчаар өмнө нь бусад хэлбэрийн мониторингийн төсөл хэрэгжүүлж байсан ТББ-ууд дундаас тухайн орон нутгийн шүүгч, прокуроруудтай аливаа сонирхлын зөрчилгүй байх шалгуурыг хангасан иргэдийг сонгосон болно. Орон нутгийн 9 ажиглагч нарт 2 өдрийн тусгай сургалт явуулж эрх зүйн суурь болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн тусгайлсан зарчмуудын талаарх ерөнхий ойлголт өгсөн болно.

Нийт 39 ажиглагчдад зориулан 2010 оны 3 дугаар сарын 31-нээс 2010 оны 4 дүгээр сарын 2-ны өдрүүдэд шүүхийн ажиглалтын арга зүйн сургалт зохион байгуулж ажиглалтыг эхлүүлсэн байна.

1.4. Ажиглалтын чиглэл

Ажиглалтаар доорх чиглэлээр мэдээлэл цуглуулан дүн шинжилгээ хийв. Үүнд:

Шударга шүүхийн стандарт хангагдсан байдал: Шүүхийн шатанд ажиглах боломжтой шударга шүүхийн стандартуудын хэрэгжилт;

Шүүх хуралдаанд оролцогчид: Шүүгч, прокурор, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгчид, шүүхийн нарийн бичгийн дарга, хэв журам сахиулах цагдаа, бусад ажилтан, орчуулагч, хэлмэрч, гэрчийн оролцоо, харилцааны соёл;

Шүүхийн цаг барилт: шүүх хуралдаан товлосон цагтаа эхэлж байгаа эсэх, хоцорсон буюу хойшилсон бол яагаад, хойшилж буйг урьдчилан мэдэгдэх боломжтой байсан эсэх;

Шүүхийн байрны нөхцөл байдал: иргэдэд үйлчлэх, тэр дундаа шүүн таслах онцгой эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага болохын хувьд шүүхийн байр нь хүндэтгэл төрүүлэхүйц, цэвэр тохилог, зай талбайн хувьд хүртээмжтэй эсэх, иргэдэд шаардлагатай мэдээллийг зохих хэлбэрээр хүргэж буй эсэх, шүүн таслах ажиллагаа иргэдэд хүртээмжтэй, хуульд заасан журмын дагуу явагдаж буй эсэх зэргийг авч үзлээ.

² Шударга шүүхийн стандартын тодорхойлолтыг хавсралтаас үзнэ үү.

1.5. Төслийн хамрах хүрээ

Шүүх хуралдааны ажиглалт төслийг 2010 оны 4 дүгээр сарын 5-наас 2010 оны 6 дугаар сарын 25-ны өдрийг дуустал нийт 12 долоо хоногийн хугацаанд хэрэгжүүлж нийслэлийн 6 дүүрэг /Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй/, 3 аймаг /Говь-Алтай, Дорнод, Хөвсгөл аймаг/ дахь Сум дундын шүүх /анхан шатны шүүх/-ийн эрүүгийн 287 шүүх хуралдааны явцыг ажиглан судалсан болно.

Эрүүгийн хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдааны явцад (иргэний болон захиргааны хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдаантай харьцуулбал) хохирогч болон шүүгдэгчийн суурь эрх, эрх чөлөөнд халдах эрсдэл ихтэй, түүнчлэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үеэр шударга шүүхийн стандартыг мөрдөх нь хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах үндэс болох тул уг хуралдааныг сонгон ажиглав.

2

ШҮҮХ ХУРАЛДААНЫ АЖИГЛАЛТЫН ДҮН

2.1. Шударга шүүхийн стандарт хангагдсан байдал

2.1.1. Нээлттэй шүүх хуралдаанаар хэргээ хэлэлцүүлэх эрх

► *Хуулийн үндэслэл*

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛИЙН 235 дугаар зүйл, Шүүхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах болон насанд хүрээгүй этгээдэд холбогдох хэрэг хянан шийдвэрлэхээс бусад бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

► *Ажиглалтын дүн*

Шүүх хуралдаан нээлттэй явагдсан талаар ажиглагчдын хариулсан байдлыг хувьчлан дараах хүснэгтээр харууллаа,

№	Шүүхийн нэр	Шүүх хуралдааныг нээлттэй явуулах шаардлага хангагдсан эсэх талаар		
		Нээлттэй явагдсан эсэх (хувь)	Оролцох хүсэлтэй хүн бүрийг оруулсан эсэх (хувь)	Оролцоход зөвшөөрөл шаардлагатай байсан эсэх (хувь)
1	Баянгол дүүргийн шүүх	90.3	89.3	93.3
2	Баянзүрх дүүргийн шүүх	100	92.3	56.4
3	Сүхбаатар дүүргийн шүүх	100	97.2	94.6
4	Сонгинохайрхан дүүргийн шүүх	96.4	96.4	64.3
5	Хан-Уул дүүргийн шүүх	88.9	81.5	81.5

№	Шүүхийн нэр	Шүүх хуралдааныг нээлттэй явуулах шаардлага хангагдсан эсэх талаар		
		Нээлттэй явагдсан эсэх (хувь)	Оролцох хүсэлтэй хүн бүрийг оруулсан эсэх (хувь)	Оролцоход зөвшөөрөл шаардлагатай байсан эсэх (хувь)
6	Чингэлтэй дүүргийн шүүх	96.3	88.5	100
7	Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх	64.3	81.8	25
8	Дорнод аймаг дахь Сум дундын I шүүх	100	100	67.6
9	Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүх	100	100	13

► **Нэмэлт тайлбар**

№	Шүүхийн нэр	Нэмэлт тайлбар
1	Баянгол дүүргийн шүүх	Нээлттэй шүүх хуралдаанд оролцох оюутнуудаас “сургуулийн хүсэлт” шаардан оролцуулаагүй тохиолдол гарсан.
2	Баянзүрх дүүргийн шүүх	Тайлбар байхгүй.
3	Сүхбаатар дүүргийн шүүх	Шүүхийн нарийн бичгийн дарга нь нээлттэй шүүх хуралдааныг сонирхогчдод “ямар нэг тэмдэглэл хөтлөхгүй байх”-ыг сануулж байлаа.
4	Сонгинохайрхан дүүргийн шүүх	Нээлттэй шүүх хуралдаанд оролцоход шүүхийн цагдаа бичиг баримт шалгаж зөвшөөрөл өгдөг.
5	Хан-Уул дүүргийн шүүх	Нээлттэй шүүх хуралдаанд сонирхогчдыг оруулахгүй, улмаар хуралдаанаас гаргасан, шүүгч “шүүх хуралдаанд дуртай нь суудаггүй юм” гэж тайлбарлаж байлаа. Нээлттэй шүүх хуралдаанд суухын тулд шүүгчээс зөвшөөрөл авахыг шаарддаг. Зөвшөөрөл хүсэхэд ямар нэг шалтгаан, тайлбар хэлэлгүйгээр “үгүй” гэдэг. Тайлбар шаардахад “гэрээ байгуулах” ёстой гэжээ.
6	Чингэлтэй дүүргийн шүүх	Оюутан сонирхох хэрэг биш, хэрэгт хамааралгүй хүн гэх мэт шалтгаанаар оролцуулдаггүй. Мөн ямар нэг шалтгаангүйгээр шүүх хуралдаанд оролцуулахгүй гэх тохиолдол гарсан.
7	Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх	Шүүгч “Ямар зорилгоор шүүх хуралдаанд суух гээд байгаа юм бэ?” гэх асуултыг заавал асуудаг, шүүхийн жижүүр “бичиг баримтгүй бол оруулахгүй” гэсэн шаардлага тавьдаг.
8	Дорнод аймаг дахь Сум дундын I шүүх	Шүүхийн нарийн бичгийн дарга нээлттэй шүүх хуралдаанд оролцох хүнээс “юун хүн бэ, ямар зорилгоор шүүх хуралдаанд оролцох гэж байгаа вэ” гэх асуултыг асуудаг.

№	Шүүхийн нэр	Нэмэлт тайлбар
9	Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүх	Нээлттэй шүүх хуралдаан хэдий ч шүүх хуралдаанд ажиглагчид зохих зөвшөөрлийг авч орсон. Шүүх хуралдаанд оролцож байсан өмгөөлөгч ажиглагч нарыг “дараагийн хуралд ор, энэ хурлаас гар” хэмээн илт эсэргүүцэн хашгирсаныг хуралдаан даргалагч болиулсан.

Ажиглалтаас үзэхэд шүүх болон шүүгч нь хуралдааныг нээлттэй явуулах хуулийн заалтыг зөрчиж, хуульд заагаагүй баримт, зөвшөөрөл шаардах, сонирхогчдыг шүүх хуралдаанд оролцуулахаас үндэслэлгүйгээр татгалзах, улмаар “ямар зорилгоор хуралдаанд оролцож байгаа, хэн болох” гэх мэтээр асууж байж хуралдаанд оролцохыг зөвшөөрдөг нь “шүүх хуралдааныг нээлттэй явуулах” зарчмыг зөрчиж байна. Нээлттэй шүүх хуралдаанд иргэдийг оролцуулах тухай журам байхгүй тул шүүх, шүүгч бүр харилцан адилгүй байдлаар асуудалд хандаж байна.

Нээлттэй шүүх хуралдаанд оролцохыг хүссэн иргэн бүрийг ямар нэг зөвшөөрөл шаардахгүйгээр шүүх хуралдаанд оролцуулах, чингэхдээ шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангах үүднээс бичиг баримт, биедээ авч яваа эд зүйлийг шалгаж байх талаар шүүх, шүүгч бүрт чиглэл өгөхүйц тодорхой нэгдсэн журам боловсруулах шаардлагатай байна.

2.1.2. Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх эрх

▶ Хуулийн үндэслэл

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН 14 дүгээр зүйл, Эрүүгийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д зааснаар хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх эрхийг ямар нэгэн ялгаваргүйгээр эдлэх ёстой.

▶ Ажиглалтын дүн

Энэ эрхийн хэрэгжилтийн төлөв байдлыг тогтоох зорилгоор шүүх хуралдааны оролцогчдоос шүүгч, болон бусад оролцогчдыг татгалзан гаргах хүсэлт гаргасан байдал болон шүүгч талуудад адил, тэгш боломж олгож байгаа эсэхэд дүн шинжилгээ хийсэн ба үр дүнг доорх хүснэгтэд харуулав.

№	Шүүхийн нэр	Шүүгч, бусад оролцогчийг татгалзан гаргасан эсэх талаар
1	Баянгол дүүргийн шүүх	5 хувьд нь даргалагч шүүгчийг, 5 хувьд нь бүрэлдэхүүний шүүгчийг татгалзан гаргах хүсэлт гаргасан байна.
2	Баянзүрх дүүргийн шүүх	4.3 хувьд нь даргалагч шүүгчийг, 6.3 хувьд нь бүрэлдэхүүний шүүгчийг, 14.7 хувьд нь бусад оролцогчийг татгалзан гаргах хүсэлт гаргасан байна.

№	Шүүхийн нэр	Шүүгч, бусад оролцогчийг татгалзан гаргасан эсэх талаар
3	Сүхбаатар дүүргийн шүүх	3.1 хувьд нь даргалагч шүүгчийг татгалзан гаргах хүсэлт гаргасан байна.
4	Сонгинохайрхан дүүргийн шүүх	2.7 хувьд нь даргалагч шүүгчийг, 2.7 хувьд нь бүрэлдэхүүний шүүгчийг, 2.7 хувьд нь бусад оролцогчийг татгалзан гаргах хүсэлт гаргасан байна.
5	Хан-Уул дүүргийн шүүх	17.4 хувьд нь даргалагч шүүгчийг, 9.5 хувьд нь бусад оролцогчийг татгалзан гаргах хүсэлт гаргасан байна.
6	Чингэлтэй дүүргийн шүүх	Татгалзан гаргах хүсэлт гаргаагүй байна.
7	Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх	10 хувьд нь бусад оролцогчийг татгалзан гаргах хүсэлт гаргасан байна.
8	Дорнод аймаг дахь Сум дундын I шүүх	Татгалзан гаргах хүсэлт гаргаагүй байна.
9	Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүх	6.3 хувьд нь даргалагч шүүгчийг, 6.3 хувьд нь бүрэлдэхүүний шүүгчийг, 6.3 хувьд нь бусад оролцогчийг татгалзан гаргах хүсэлт гаргасан байна.

Шүүхийн өмнө эрх тэгш байна гэдэг нь хүмүүс шударга, хөндлөнгийн хараат бус шүүхийн өмнө хуульчлан бүрдүүлсэн нөхцөл, боломжид тулгуурлан өөрийн эрх, ашиг сонирхлоо хамгаалах явдал юм.⁴ Ажиглалтын явцад шүүгдэгч болон хохирогчийн зүгээс шүүх хуралдаан даргалагч, бүрэлдэхүүний бусад шүүгч, яллагч, шүүхийн нарийн бичгийн даргаас татгалзах эрхээ хэрхэн хэрэгжүүлж буйг авч үзэхэд цөөн тохиолдолд шүүгч, бусад оролцогчоос татгалздаг гэсэн дүн гарч байна. “Татгалзан гаргах эрх”-ийн хэрэгжилттэй холбоотой бусад асуудлыг авч үзэхэд Баянзүрх, Хан-Уул дүүргийн шүүхийн хувьд хуралдаан даргалагч “татгалзан гаргах үндэслэл” буюу эрхийг тодорхой тайлбарлаж өгөхгүй байх тохиолдол ажиглагдлаа. Шүүгч болон бусад оролцогчоос “татгалзан гаргах хүсэлт гаргах” нь шүүгдэгч, хохирогчийн эрхийн асуудал тул энэхүү эрхээ бүрэн эдлэх боломжийг хангах үүднээс шүүгчид “татгалзан гаргах эрх болон татгалзан гаргах үндэслэлийг тодорхой тайлбарлах” үүргээ бүрэн хэрэгжүүлэх тал дээр онцгой анхаарах нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл, шүүх хуралдаан даргалагчид шүүгдэгч, хохирогчдод “татгалзах эрх” болон ямар үндэслэлээр татгалзах учиртайг сайтар тайлбарлаж өгөх шаардлага буй нь шүүн таслах ажиллагааны практикаас харагдаж байна.

³ Ж.Бямбаа. Шүүн таслах ажиллагаан дах мэтгэлцэх зарчим ба хүний эрх, эрх чөлөө. Хүний эрх сэтгүүл 2005 он, № 1. 54 дүгээр тал

Шүүгч талуудад адил тэгш боломж олгосон буюу хараат бусаар гадны нөлөөнд авталгүй шийдвэр гаргасан байдлыг ажиглалтын дүнгээр харуулбал:

№	Шүүхийн нэр	Шүүгч талуудад адил тэгш боломж олгосон (%)	Шүүгч хараат бусаар аль нэг талд үйлчлэхгүйгээр, гадны нөлөөнд автахгүйгээр шийдвэр гаргасан (%)
1	Баянгол дүүргийн шүүх	100	94.4
2	Баянзүрх дүүргийн шүүх	94.4	91.7
3	Сүхбаатар дүүргийн шүүх	96.3	100
4	Сонгинохайрхан дүүргийн шүүх	100	100
5	Хан-Уул дүүргийн шүүх	90.9	90.5
6	Чингэлтэй дүүргийн шүүх	93.8	94.1
7	Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх	100	100
8	Дорнод аймаг дахь Сум дундын I шүүх	85.7	100
9	Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүх	84.6	84.6

Дээрх хүснэгтээс харахад, ажиглагчид шүүх хуралдаан даргалагч шүүгч талуудад адил тэгш боломж олгох, хараат бусаар, аль нэг талд үйлчлэхгүйгээр, гадны нөлөөнд автахгүйгээр шийдвэр гаргаж буй байдалд нэлээд өндөр үнэлгээ өгсөн ба энэ нь шүүгч хохирогч, шүүгдэгчийн “хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх” эрхийг хангаж буйг илэрхийлж байна.

2.1.3. Шүүгч шүүх хуралдаанд оролцогчдын эрхийг тайлбарлаж, ойлгуулсан эсэх талаар


▶ Хуулийн үндэслэл

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛИЙН 260 дугаар зүйлийн 260.1-д зааснаар шүүх хуралдаан даргалагч нь шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч, шинжээч нарт Үндсэн хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар олгосон эрх, үүргийг тайлбарлаж өгөх үүрэгтэй.

▶ Ажиглалтын дүн

Шүүх хуралдаан даргалагч хуулиар хүлээлгэсэн үүргээ хэрхэн хэрэгжүүлж буй байдалд, оролцогчийн эдлэх эрх нэг бүрийг хэрхэн тайлбарлаж буйд хийсэн ажиглалтын дүнг доор асуулга бүрээр харуулав:


- Шүүгдэгчийн ямар хэрэгт яллагдах гэж буйгаа мэдэх эрхийг сануулсан




- Яллах дүгнэлттэй танилцах эрхийг сануулсан




- Яллагчийн уншиж сонгосон яллах дүгнэлт шүүгдэгчийн гардаж авсан яллах дүгнэлттэй тохирсон эсэхийг тодруулсан




- Өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч авах эрхийг сануулсан




- Өмгөөлөгчтэйгөө ганцаарчлан уулзах эрхийг сануулсан




- Өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, гэм буруутай эсэхээ нотлох үүрэг хүлээхгүй байхыг сануулсан




- Нотлох баримт гаргаж өгөх, шалгуулах эрхийг сануулсан




- Хэргийн материалтай танилцах эрхийг сануулсан




- Шүүх хуралдаанд оролцох эрхийг сануулсан




- Татгалзан гаргах эрхийг сануулсан




- Байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчдийн шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах эрхийг сануулсан




- **Шинжээчийн дүгнэлттэй танилцах эрхийг сануулсан**




- **Эх хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах эрхийг сануулсан**




- **Шүүх хуралдаанд эцсийн үг хэлэх эрхийг сануулсан**



- Шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах эрхийг сануулсан



- Шүүгч шүүхээс гарсан шийдвэрийг оролцогчдод тайлбарласан



Шүүх хуралдаан даргалагч шүүгч хэргийн оролцогчдод хуулиар олгосон эрхийг бүрэн эдлүүлэх үүднээс шүүх хуралдаан эхлэх шатанд тэдний эдлэх эрхийг нэг бүрчлэн тайлбарлаж өгөх үүрэгтэй. Ийм учраас шүүгч оролцогч этгээдүүдийн эдлэх эрхийг тайлбарлан сануулсан эсэхийг хуульд заасан эрх нэг бүрээр харьцуулан ажиглахад тухайн шүүгчээс хамааран харилцан адилгүй дүр зураг гарч байна. Иймд шүүх, шүүгч бүр зураглалаар харуулсан ажиглалтын дүнд дүгнэлт хийж, цаашид хэргийн оролцогчдод хуулиар олгосон эрх нэг бүрийг сануулснаар тэд эрхээ хэрэгжүүлэх боломж бүрдэнэ гэдгийг анхаарах нь зүйтэй юм. Мөн дээр дурдсан эрхүүд нь “байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчдийн хувьд энгийн бөгөөд ойлгомжтой” мэт боловч иргэдэд тэр бүр ойлгомжтой байдаггүйг санахад илүүдэхгүй юм. Шүүгч шүүхээс гарсан шийдвэрийг тайлбарлахдаа хэт “хуулийн хэллэг”-ээр тайлбарлах, зарим ялын учир холбогдлыг тайлбарлаагүйгээс оролцогчид шүүхийн шийдвэрийг ойлгохгүй үлддэг байна.

Иймд шүүгчээс шүүх хуралдаанд оролцогчдын эрх, үүргийг хэр зэрэг ойлгомжтой тайлбарласан талаар ажиглагчид дараах үнэлгээг хийсэн байна.

№	Шүүхийн нэр	Шүүгчийн оролцооны талаарх үнэлгээ
1	Баянгол дүүргийн шүүх	51.4 хувьд нь оролцогчдын эрх, үүргийг ойлгомжтой тайлбарлаж өгсөн бөгөөд өмнө нь хойшилсон шүүх хуралдааны тухайд эрх, үүргийг өмнө нь тайлбарласан хэмээн тайлбарлаагүй.
2	Баянзүрх дүүргийн шүүх	81.4 хувьд нь оролцогчдын эрх, үүргийг ойлгомжтой тайлбарлаж өгсөн.
3	Сүхбаатар дүүргийн шүүх	93.5 хувьд нь оролцогчдын эрх, үүргийг ойлгомжтой тайлбарлаж өгсөн байна.
4	Сонгинохайрхан дүүргийн шүүх	81.8 хувьд нь оролцогчдын эрх, үүргийг ойлгомжтой тайлбарлаж өгсөн байна.
5	Хан-Уул дүүргийн шүүх	62.5 хувьд нь оролцогчдын эрх, үүргийг ойлгомжтой тайлбарлаж өгсөн боловч маш ойлгомжгүй бөгөөд хурданаар уншдаг; эрх, үүргийг хуулийн заалт дурдах төдийгөөр тайлбарласан тохиолдлууд ажиглагдсан
6	Чингэлтэй дүүргийн шүүх	86.4 хувьд нь оролцогчдын эрх, үүргийг ойлгомжтой тайлбарлаж өгсөн бөгөөд хойшилсон шүүх хуралдааны тухайд эрх, үүргийг өмнө нь тайлбарласан хэмээн тайлбарлаагүй тохиолдол гарсан
7	Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх	Ажиглалтын бүх тохиолдолд оролцогчдын эрх, үүргийг ойлгомжтой тайлбарлаж өгсөн.
8	Дорнод аймаг дахь Сум дундын I шүүх	Ажиглалтын бүх тохиолдолд оролцогчдын эрх, үүргийг ойлгомжтой тайлбарлаж өгсөн.
9	Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүх	87.5 хувьд нь оролцогчдын эрх, үүргийг ойлгомжтой тайлбарлаж өгсөн.

Шүүгчдийн хувьд шүүх хуралдаанд оролцогчдын эрх, үүргийг ухуулан ойлгуулах нь шүүхийн мэтгэлцээний хэрэгжилтийг хангаж буй нэг чухал үзүүлэлт юм. Зарим шүүгч оролцогчдын эрх үүргийг тайлбарлах биш зөвхөн танилцуулдаг бол зарим нь хохирогчид гомдолтой, гомдолгүй гэхийн учир холбогдол, үр дагаврыг болон шүүгдэгч эцсийн үгэндээ юу багтааж хэлэх талаар маш ойлгомжтой, тодорхой тайлбарлаж өгч байсан болно.

Говь-Алтай болон Дорнод аймаг дахь Сум дундын шүүхийн шүүх хуралдааныг даргалагч нь оролцогчдын эрх, үүргийг ойлгомжтой тайлбарлаж өгсөн бол бусад шүүхийн хувьд хангалтгүй байгаа нь дээрх хүснэгтээс харагдаж байна. Шүүгчид оролцогчдын эрх үүргийг танилцуулах биш тайлбарлах, тухайлбал, хохирогчид гомдолтой, гомдолгүй гэхийн учир холбогдол, үр дагаврыг болон шүүгдэгч эцсийн үгэндээ юу багтааж хэлэх талаар маш ойлгомжтой, тодорхой хэлж өгч хэвшихийг санал болгож байна.

2.1.4. Оролцогчид шүүх хуралдааны явцад хуулиар өөрт нь олгогдсон боломжоор хангагдаж байсан эсэх талаар


▶ Хуулийн үндэслэл

ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг⁴, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 17 дугаар зүйлд зааснаар шүүн таслах ажиллагаа нь эрх тэгш бүхий яллах, өмгөөлөх талын мэтгэлцээний үндсэн дээр явагдах бөгөөд ийнхүү мэтгэлцэхийн тулд талууд шүүх хуралдааны явцад хуулиар олгосон боломж буюу эрхээр хангагдах учиртай.


▶ Ажиглалтын дүн

Шүүх хуралдааны явцад шүүгдэгч болон түүний өмгөөлөгч зохих боломжоор хангагдаж байсан эсэхийг дор дурдсан хүрээнд ажиглалаа.

- Шүүгдэгч болон түүний өмгөөлөгчид хэргийн материалтай танилцах боломж




- Шүүгдэгч болон түүний өмгөөлөгчид яллагчаас асуулт /нотлох баримт, фактын талаар/ асуух боломж




⁴ Шүүн таслах ажиллагааг мэтгэлцэх зарчмын үндсэн дээр явуулна.

- **Гэрч, шинжээчийг шүүх хуралдаанд оролцуулж, мэдүүлэг авах боломж**



- **Шинээр нотлох баримт гаргаж, танилцуулах боломж**



Ажиглагчдын дүгнэснээр шүүх хуралдаанд оролцогчид нь хэргийн материалтай танилцах боломжоор бүрэн хангагддаг байна. Харин шүүгдэгч болон шүүгдэгчийн өмгөөлөгч нар яллагчаас асуулт асуух боломжоор төдийлөн хангагддаггүй, зөвхөн шүүмжлэлийн шатанд бие биенийхээ саналд хариу болгож санал хэлэх байдлаар мэтгэлцэх нь нийтлэг байна. Мөн ялагч нь мэтгэлцээний нэг тал атлаа хэрэг үүсгэх шатнаас эхлэн хэргийн материалтай танилцаж, яллах нотлох баримт бүрдүүлэх, улмаар шүүх хуралдааны мэтгэлцээний үед бусад оролцогч түүнээс асуулт асуух эрхгүй байгаа нь ялагч талд хэт давуу байдал бий болгож байна. Иймд шүүгч нар шүүгдэгч, түүний өмгөөлөгчдөд ялагчид асуулт тавих боломжоор хангаж, мэтгэлцээнийг жинхэнэ буюу хуульд заасан утгаар нь хэрэгжүүлэхэд онцгой анхаарах хэрэгтэй байна.

Мөн шүүх хуралдаанд гэрч, шинжээчийг оролцуулж, мэдүүлэг авах боломж хангалттай байдаг боловч практикт зөвхөн мэтгэлцэгч талуудын хүсэлтийг үндэслэн энэхүү боломж хангагдаж байна. Түүнчлэн мэтгэлцэгч талууд идэвхигүй, зарим тохиолдолд мэдлэг, чадваргүй байдлаасаа шалтгаалан энэхүү боломжоо алдаж байна.

Эрүүгийн шүүх хуралдааны явцад шүүгдэгч шүүх болон яллах талын асуултад босч, өмгөөлөх талын асуултад сууж хариулах байдал хэвшин тогтсон нь ажиглагдаж байсан ба ЭБШХ-д яллах тал асуулт асуухад болон шүүмжлэл явуулахад босох, суух тухай заалт байхгүй харин ЭБШХ-ийн 251.2 дугаар зүйлд шүүх хуралдаанд оролцогчид шүүхэд хандан мэдүүлэг өгөх, үг хэлэхдээ суудлаасаа

босно гэж заасан байна. Энэ нь талуудын адил эрхтэйгээр мэтгэлцэх зарчмыг зөрчиж, яллах талд давуу эрх олгож буй сэтгэгдэл төрүүлж байв.

Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд яллах тал асуулт асуухад болон шүүмжлэл явуулахад босох, суух тухай заалт байхгүй тул энэ байдлыг арилгах замаар мэтгэлцэгч талуудын тэгш байдлыг хангах, шүүх хуралдааны шүүмжлэлийн шатанд талуудын эсэргүүцсэн санал гаргах боломжийг тоон үзүүлэлтээр хязгаарласан нь талуудын мэтгэлцэх боломжийг хязгаарлаж буй тул ЭБШХ-ийн 279 дүгээр зүйлийн 279.6-д зохих өөрчлөлт оруулах зэрэг зарим тодорхой санал байна.

Шүүх хуралдааны шүүмжлэлийн шатанд талуудын эсэргүүцсэн санал гаргах боломжийг тоон үзүүлэлтээр хязгаарласан нь талуудын мэтгэлцэх боломжийг хязгаарлаж буй нэг хэлбэр болж байна /ЭБШХ-ийн 279.6/.

Талуудын мэтгэлцэх ур чадвар шаардлагын түвшинд хүрээгүй байгаа нь дараах байдлаар тайлбарлагдана:

- Шүүхийн хэлэлцүүлгийн үед илэрхий зөрүүтэй асуудал байсаар атал нэмэлт асуулт, санал тавихгүй байна.
- Хөтөлсөн, тулгасан асуулт асууж ЭБШХ-ийн 144.6 дугаар зүйлийг зөрчиж байна. Мөн асуулт асуухыг эсэргүүцэхгүй байгаа нь талуудын хөтөлсөн болон тулгасан асуултын шинж чанарыг мэдэхгүй байгаа байдлыг харуулж байна.
- Зарим тал хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтад найдаж, шүүх хуралдааны явцад мэтгэлцэн өөрийн давуу байдлаа харуулдаа хайнга ханддаг.
- Талууд шүүхэд байр сууриа илэрхийлэхдээ чиг үүргээ барихгүй, тухайлбал, шүүхийн хэлэлцүүлгийн үед ялагч тал шүүгдэгчийн үйлдлийг хөнгөрүүлэх шинж чанартай асуултыг илт хөтлөн асуух;
- Талууд өөрсдийн байр суурийг нотлох биш, аль аль нь яллах болон цагаатгах шинжтэй асуултуудыг тодорхой зорилгогүй хольж асуух;
- Нотлох баримтыг шинжлэхдээ ур чадвар дутагдах гэх мэт.

Мэтгэлцээний чухал хэсэг болох шүүмжлэлийн үг нь үндэслэл муутай, тухайлбал, ялагч гэм буруутай, зүйл анги тохирсон, ял халдаах үндэслэлтэй байна гэдэг бол өмгөөлөгч нь шүүгдэгчийн хувийн байдлыг ярихаас хэтрэхгүй байна. Шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэндээ гэмшиж байгаа, өвчтэй зовлонтой, эцэг эх нь өндөр настай, нялх нойтон хүүхэдтэй тул хуульд заасан хөнгөн ял оногдуулж өгнө үү гэх мэт нэг загварын цөөн үгээр шүүмжлэл явуулж байна. Талууд эрх зүйн үндэслэлтэй шүүмжлэл хэлэх чадвар муутай байв.

Шүүгдэгчийн эцсийн үг мэтгэлцээний нэмэлт механизм болох ач холбогдолтой зүйл атал энэ талаар шүүгч, шүүгдэгчийн өмгөөлөгч нар тодорхой тайлбарлаж өгөөгүйгээс шүүгдэгч бүр хэвшил болсон, ахуйн чанартай хэдэн үг хэлэхээс биш хэрэг маргааны талаар эрх зүйн үндэслэлтэй үг хэлж чадахгүй байгаа явдал нийтлэг байв.

Шинээр нотлох баримт гаргах, танилцуулах боломжийн тухайд шүүгч нар харилцан адилгүй байр суурьтай байдаг. Хохирогч, шүүгдэгч нарын хувийн байдлыг нотлох баримтыг гаргаж танилцуулах боломжийг олгодог атлаа гэмт хэргийн улмаас учирсан хохирлын үнэлгээ гэх мэт нотлох баримтыг гаргах, танилцуулах боломжийг хязгаарладаг. Үүний зэрэгцээ нотлох баримт шинжлэн судлах шатанд зарим эд мөрийн баримтыг судалдаггүй, шүүх хуралдааны дараалал зөрчиж судлах тохиолдол гардаг ажээ. Жишээлбэл, Дорнод аймаг дахь Сум дундын I шүүхийн шүүх хуралдаанд ажиглалт хийсэн 2 тохиолдолд “эд мөрийн баримт хадгалах өрөөний түлхүүр хариуцсан ажилтан байхгүй” гэх шалтгаанаар эд мөрийн баримт судлах ажиллагаа тогтоосон дарааллаас хойш судлагдсан байна.

2.2. Шүүх хуралдаанд оролцогчдын оролцоо

2.2.1. Шүүгч

Шүүгчийн шүүх хуралдаанд оролцох оролцооны талаарх үнэлгээ

► Хуулийн үндэслэл

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛИЙН 15 дугаар зүйлийн 15.1-д зааснаар эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана. Мөн хуулийн 235 дугаар зүйлийн 235.1-д “төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах болон насанд хүрээгүй этгээдэд холбогдох хэрэг хянан шийдвэрлэхээс бусад бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг нээлттэй явуулна”, 237 дугаар зүйлийн 237.2-т “шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдааныг гагцхүү тухайн хэрэгт холбогдолтой асуудлыг хянан шийдвэрлэхэд чиглүүлж, хэргийг бүх талаас нь бүрэн, бодитойгоор шинжлэн судалж, үнэн байдлыг тогтоохын тулд хуульд заасан арга хэмжээг авна”, мөн зүйлийн 237.3-т “шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдааны дэгийг сахиулах арга хэмжээ авч оролцогчид эрх, үүргийг нь тайлбарлан өгнө” гэж тус тус заажээ.

► Ажиглалтын дүн

Хэрэг, маргааныг шийдвэрлэхэд нотлох баримтыг үндэслэх, хуулийн ямар зүйл, заалт хэрэглэх эрхийг гагцхүү шүүгч эдэлдэг тул энэхүү өндөр хариуцлагатай албандаа хүндэтгэлтэй хандан, шүүн таслах үйл ажиллагаа нь шүүгчийн өөр бусад бүх ажлаас ямагт илүү чухал байж, шүүн таслах ажлын талаар бусдад буруу ойлголт төрүүлэхээс зайлсхийж, шүүгчийн зүгээс хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг өөрийн үг яриа, үйлдлээрээ төрүүлж байх ёстой.

Шүүх хуралдаан даргалагч болон шүүх бүрэлдэхүүний шүүгч нар шүүх хуралдааны үед хуульд заасан дээрх эрх хэмжээгээ хэрхэн хэрэгжүүлж буйд дүгнэлт хийлээ.

№	Шүүхийн нэр	Шүүгчийн оролцооны талаарх үнэлгээ
1	Баянгол дүүргийн шүүх	• Шүүгчийн оролцоо жигд, ямарваа нэг илэрхий дутагдал ажиглагдсангүй.
2	Баянзүрх дүүргийн шүүх	• Шүүгч нар шүүх хуралдаан эхэлснээс хойш орж ирдэг; • Даргалагч шүүгчээс бусад нь шүүх хуралдаанд идэвхигүй ханддаг; • Шүүх бүрэлдэхүүн болон шүүгч хуралдааны явцад мэтгэлцээнд анхаарал хандуулахгүй хоорондоо болон утсаар ярих, өөр хэргийн материал унших нь анзаарагдаж байв.

№ Шүүхийн нэр	Шүүгчийн оролцооны талаарх үнэлгээ
3 Сүхбаатар дүүргийн шүүх	<ul style="list-style-type: none"> • Ажиглалтын 31.8 хувьд нь шүүхийн шийдвэр нотлох баримтад үндэслэж гараагүй гэж үзжээ. • Шүүгч нар нь ЭБШХ-д заасан шүүх хуралдааны дарааллын дагуу хуралдааныг явуулаагүй нь хуралдааныг ойлгомжгүй, цэгцгүй болгож байв. • Шүүгч нар шүүх хуралдааны үеэр орж гарах, хоорондоо ярих, инээлдэх, зөвлөлдөх тасалгааны хаалгаар хүнтэй ярих, сонин унших, компьютер ашиглах зэргээр мэтгэлцээнд анхаарлаа хандуулахгүй байлаа. • Шүүгч шүүх хуралдааны хэлэлцүүлгийн үед тулгасан, шаардсан асуулт асуух, шүүгдэгчийг “худлаа яриад бай”, “хачин юм ярихгүй шүү” гэх мэтээр загнах хандлага гаргаж байв. • Шүүх бүрэлдэхүүн орж ирээгүй байхад хуралдааныг эхэлж хууль зөрчсөн.
4 Сонгинохайрхан дүүргийн шүүх	<ul style="list-style-type: none"> • Ажиглалтын 8.9 хувьд нь шүүхийн шийдвэр нотлох баримтад үндэслэж гараагүй гэж үзжээ; • Шүүгч нь шүүх хуралдааны хэлгүй, дүлий оролцогчид хэлмэрч авах эрхийг нь тайлбарлан таниулж олгоогүйгээс шүүгдэгч шүүх хуралдааны явцыг төдийгүй шүүхийн шийдвэрийг ойлгосонгүй⁵. • Шүүгч нар шүүх хуралдааны үеэр орж гарах, хоорондоо ярих, инээлдэх, зөвлөлдөх тасалгааны хаалгаар хүнтэй ярих, сонин унших, компьютер ашиглах зэргээр мэтгэлцээнд анхаарлаа хандуулахгүй байсан.
5 Хан-Уул дүүргийн шүүх	<ul style="list-style-type: none"> • Даргалагч шүүгч шүүхийн хэлэлцүүлгийн үед утсаар ярьсан; • Шүүх хуралдааныг нээхэд бүрэлдэхүүний шүүгч орж ирээгүй ба хурал эхэлснээс хойш орж ирсэн;
6 Чингэлтэй дүүргийн шүүх	<ul style="list-style-type: none"> • Ажиглалтын 86.4 хувьд нь даргалагч шүүгч шүүх хуралдааныг нээлттэй явуулах зарчмыг зөрчсөн. Зөвшөөрөл авах ёстой, мөн оюутан сонирхох хэрэг биш, хэрэгт хамааралгүй хүн гэх мэтээр шалтаглаж байв.
7 Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх	<ul style="list-style-type: none"> • Шүүгчийн оролцоо жигд, ямарваа нэг илэрхий дутагдал ажиглагдаагүй.
8 Дорнод аймаг дахь Сум дундын I шүүх	<ul style="list-style-type: none"> • Шүүгч шүүгдэгчийн биеийн байцаалтыг хуралдааны эхэнд шалгах үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байна. Ажигласан 2 шүүх хуралдаанд шүүгдэгчийн овог нэрийг асуух төдийгээр хуралдааныг үргэлжлүүлсэн. • Шүүгдэгчдэд ямар хэрэгт яллагдаж байгааг нь танилцуулсангүй. • Шүүгдэгч болон түүний өмгөөлөгчдийг улсын яллагчаас асуулт асуух эрхээр хангаагүй.
9 Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүх	<ul style="list-style-type: none"> • Шүүгчийн оролцоо жигд, ямарваа нэг илэрхий дутагдал ажиглагдаагүй.

Шүүх хуралдаанд ажиглалт хийх явцад шүүгч нар уг шаардлагыг хараахан хангахгүй, хуулийн заалтыг зохих ёсоор хэрэгжүүлэхгүй байгаа нь харагдаж байна. Эмзэглүүштэй нь шүүгч нар шүүх хуралдааны оролцогчдын эрхийг хангалттай бүрэн тайлбарлан ойлгуулахгүй, түүнийг нь бүрэн

⁵ Сонгино Хайрхан дүүргийн 2010 оны 6 сарын 16-нд болсон шүүх хуралдаан

эдлүүлэхгүй байгаагийн улмаас хүний эрх зөрчигдөх, цаашилбал хуульд заасан бүрэлдэхүүнгүйгээр шүүх хуралдааныг эхлүүлэх, мэтгэлцэгч талуудын мэтгэлцээнд анхаарал хандуулахгүй байх, шүүх хуралдааны үеэр утсаар ярих, шүүх хуралдааны бус үед яллагч буюу мэтгэлцээний нэг талтай илт дотно харилцах гэх мэт зүй бус байдал гаргадаг байна.

Шүүхийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт “шүүгч өмсгөлтэй байна” хэмээн заасан байдаг. Харин Сонгинохайрхан дүүргийн шүүхийн тухайд 2 удаагийн ажиглалтад шүүгч өмсгөлгүйгээр шүүх хуралдаанд орсноос бусад тохиолдолд ажиглалтад хамрагдсан бүх шүүх хуралдаанд шүүгч нар өмсгөлөө өмсөж орсон байна.

Бүрэлдэхүүнтэй шүүх хуралдааныг шүүх бүрэлдэхүүн бүрдээгүй байхад эхлүүлдэг, улмаар шүүх хуралдааны дундуур шүүгч орж гардаг, шүүгч хавтаст хэрэгт авагдсан баримт нотолгоо, өөрийн дүн шилжилгээ хийж боловсруулсан төсөөлөл болон мэтгэлцээний үр дүнг харьцуулан шийдвэр гаргах ёстой атал зарим тохиолдолд шүүх хуралдааны явцад мэтгэлцээнд анхаарлаа хандуулахгүй өөр бусад юм уншдаг, зарим оролцогчийн ярьж буй зүйлийг таслан зогсоох буюу аль нэг талд ашигтай асуулт тавьдаг зэргийг таслан зогсоох замаар шүүгчийн биеэ авч явах байдлыг сайжруулж шүүгч шүүх хуралдаанд хөндлөнгийн байр сууринаас оролцох байдлыг хэвшүүлэх шаардлагатай.

2.2.2. Улсын яллагч

► Хуулийн үндэслэл

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН 56 дугаар зүйлийн 56.1, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д зааснаар прокурор нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс улсын яллагчаар оролцоно.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 238 дугаар зүйлийн 238.1-д “улсын яллагч, шүүгдэгч, өмгөөлөгч, түүнчлэн хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч нь хүсэлт, нотлох баримт гаргах, түүнийг шинжлэхэд оролцох, үг хэлэх талаар тэгш эрх эдэлнэ”, мөн хуулийн 239 дүгээр зүйлийн 239.1-т “прокурор шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцож, нотлох баримтыг шинжлэх, шүүх хуралдааны явцад гарсан асуудлын талаар санал гаргах, шүүгдэгчид ял оногдуулахад баримтлах Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг, ялын төрөл, хэмжээ, хорих ял эдлүүлэх дэглэмийн болон бусад асуудлын талаарх дүгнэлтээ шүүхэд гаргана”, 239.2-т “улсын яллагч хуулийн шаардлага ба хэргийн бүх байдлыг үндэслэн өөрийн дотоод итгэлийг удирдлага болгон яллана” гэж тус тус заажээ.

Прокурорын байгууллагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.6-д зааснаар прокурор нь дүрэмт хувцастай байх ба прокурорын дүрэмт хувцсанд прокурорын зэрэг дэвийг тусгасан ялгах тэмдэг байна. Тэдгээрийн загвар, хэрэглэх журмыг Ерөнхийлөгч батална хэмээн заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч 1996 оны 2 дугаар сарын 17-ны өдөр 26 тоот зарлиг гарган “Прокурорын дүрэмт хувцасны загвар, прокурорын зэрэг дэвийг ялгах тэмдгийн загвар, прокурорын дүрэмт хувцсыг хэрэглэх журам”-ыг баталсан байна.

► **Ажиглалтын дүн**

Улсын яллагч нь Үндсэн хуульд заасны дагуу шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг бүхий оролцогч. Тэр дундаа эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу эрүүгийн шүүх хуралдаанд нотлох баримтыг шинжлэх, шүүх хуралдааны явцад гарсан асуудал болон шүүгдэгчид оногдуулах ялын талаар санал гаргах зэрэг чухал эрх бүхий этгээд юм.

Улсын яллагч шүүх хуралдаанд оролцохдоо хуулийн дээрх заалтад заасан эрх, үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаад дараах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

№	Шүүхийн нэр	Улсын яллагчийн оролцооны талаарх үнэлгээ
1	Баянгол дүүргийн шүүх	Шүүх хуралдаанд дүрэмт хувцсаа өмсөөгүй тохиолдол байсан бөгөөд нэг тохиолдолд шүүх хуралдаан завсарлаж шийдвэр сонсоход улсын яллагч явсан байв.
2	Баянзүрх дүүргийн шүүх	Улсын яллагчийн оролцоо жигд, илэрхий дутагдал ажиглагдсангүй.
3	Сүхбаатар дүүргийн шүүх	Шүүгдэгчтэй бүдүүлэг байдлаар харилцаж “худлаа ярь” гэх мэтээр загнах тохиолдол гарсан.
4	Сонгинохайрхан дүүргийн шүүх	Улсын яллагчийн оролцоо жигд, илэрхий дутагдал ажиглагдсангүй.
5	Хан-Уул дүүргийн шүүх	Шүүх хуралдаанд дүрэмт хувцсаа өмсөөгүй 5 тохиолдол гарсан.
6	Чингэлтэй дүүргийн шүүх	Шүүх хуралдаанд дүрэмт хувцсаа өмсөөгүй 1 тохиолдол гарсан.
7	Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх	Улсын яллагчийн оролцоо жигд, илэрхий дутагдал ажиглагдсангүй.
8	Дорнод аймаг дахь Сум дундын I шүүх	Улсын яллагчийн оролцоо жигд, илэрхий дутагдал ажиглагдсангүй.
9	Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүх	Улсын яллагчийн оролцоо жигд, илэрхий дутагдал ажиглагдсангүй.

Нийслэлийн дүүрэг болон хөдөө орон нутгийн алинд ч улсын яллагч шүүх хуралдаанд идэвхитэй мэтгэлцэж, төрийн нэрийн өмнөөс яллах үүргээ хангалттай хэрэгжүүлж байна хэмээн ажиглагчид дүгнэжээ. Гэсэн хэдий ч тэд шүүх хуралдааны хэлэлцүүлгийн шатанд та хохирлоо төлсөн үү, гэм буруугаа ойлгож байна уу, өөр үйлдсэн хэрэг байна уу гэх мэт нэг загвартай асуулт тавихаас биш хэргийн талаар эрх зүйн үндэслэлтэй, ялагаагаа нотлоход чиглэсэн оновчтой асуулт асуух нь цөөн ажиглагдаж байлаа. Мөн өмгөөлөгч зүйл ангийг өөрчлөх, үйлдэл холбогдлыг хэрэгсэхгүй болгох санал гаргаж байхад улсын яллагч ямар нэг санал дүгнэлт хэлэхгүй байх, асуултын шинж чанар хууль зөрчсөн шинжтэй байхад ч анхаарахгүй байх тохиолдол гарч байсан байна.

Үүнээс гадна улсын яллагч шүүх хуралдаанд дүрэмт хувцсаа өмсөхгүй, шүүх хуралдаанаас хоцрох буюу цаг баримтлахгүй байх, мөн шүүх хуралдаанаас гарсан шийдвэрийг уншиж сонсоход байхгүй байх гэх мэт дутагдал байгааг дурдах нь зүйтэй.

Улсын яллагч нарын наад зах нь шүүх хуралдаанд дүрэмт хувцастай оролцох байдлыг нэг мөр болгон дэгийн хувьд зөрчсөн тохиолдолд арга хэмжээ авах, мэтгэлцэх ур чадвараа сайжруулах харилцааны соёлд анхаармаар байна.

2.2.3. Өмгөөлөгч

► Хуулийн үндэслэл

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛИЙН 17 дугаар зүйлийн 17.1-д “шүүн таслах ажиллагаа нь эрх тэгш бүхий яллах, өмгөөлөх талын мэтгэлцээний үндсэн дээр явагдана”, 17.3-т “өмгөөлөгч нь шүүгдэгчийг өмгөөлөхийн тулд хуульд заасан бүхий л арга хэрэгслээр хууль зүйн туслалцаа үзүүлнэ”, 17.4-т “талууд шүүх хуралдааны үед нотлох баримтыг шинжлэн судлахад оролцох, хүсэлт гаргах, хэрэгт ач холбогдол бүхий ямар ч асуудлаар саналаа илэрхийлэх талаар эрх тэгш байна”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн бусад туслалцаа авах эрхтэй” хэмээн өмгөөлөгчийн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцох үндсийг тус тус тодорхойлжээ. Өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцоходоо Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 241 дүгээр зүйлийн 241.1-д зааснаар нотлох баримт шинжлэхэд оролцох, шүүх хуралдааны явцад гарсан асуудлаар санал гаргах, шүүгдэгчийг цагаатгах, түүний хариуцлагыг хөнгөрүүлэх байдлын тухай болон шүүгдэгчид оногдуулах ялын талаар саналаа хэлэх эрхтэй.

► Ажиглалтын дүн

Ажиглалтын явцад өмгөөлөгчийн хувьд шүүх хуралдаанд оролцож буй оролцоог нь нийтлэг байдлаар дүгнэсэн болно.

№	Шүүхийн нэр	Шүүгдэгчийн өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцсон эсэх /хувь/		Хохирогчийн өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцсон эсэх
		Өмгөөлөгчөө өөрөө сонгосон эсэх	Өмгөөлөгчийг төрөөс томилсон эсэх	
1	Баянгол дүүргийн шүүх	-	93.1 ⁶	8.7
2	Баянзүрх дүүргийн шүүх	70.6	87.5 ⁷ 24.2	13.9
3	Сүхбаатар дүүргийн шүүх	80	97.4 20.6	13.5
4	Сонгинохайрхан дүүргийн шүүх	71.1	83.3 31.6	11.9

⁶ 29 асуулгын хуудасны дүнгээс тооцсон хувь

⁷ 40 асуулгын хуудасны дүнгээс тооцсон хувь

№	Шүүхийн нэр	Шүүгдэгчийн өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцсон эсэх /хувь/		Хохирогчийн өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцсон эсэх
		Өмгөөлөгчөө өөрөө сонгосон эсэх	Өмгөөлөгчийг төрөөс томилсон эсэх	
5	Хан-Уул дүүргийн шүүх	76	38.1	22.7
6	Чингэлтэй дүүргийн шүүх	90.5	11.8	21.1
7	Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх	100	12.5	40
8	Дорнод аймаг дахь Сум дундын I шүүх	-	-	11.1
9	Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүх	100	4.8	27.3
9	Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүх	100	4.8	27.3

Ажиглагчид шүүх хуралдаанд шүүгдэгчийн өмгөөлөгчийн оролцоо харьцангуй өндөр хувьтай байгаа ч хохирогчид тэр бүр өмгөөлөгчтэй оролцохгүй байна гэж дүгнэсэн байна. Түүнчлэн өмгөөлөгчийн шүүх хуралдаанд оролцож буй оролцооны талаар дараах дүгнэлтэд хүрсэн байна. Үүнд:

- Шүүгдэгчийн өмгөөлүүлэх эрх хангагдаж байгаагаас гадна өмгөөлөгчөө өөрсдөө сонгох эрхээ хэрэгжүүлж байна.
- Хохирогч нар шүүх хуралдаанд ихэнхи тохиолдолд өмгөөлөгчгүй оролцож байна.
- Өмгөөлөгч нар шүүх хуралдаан эхлэхийн өмнө л хэргийн материалтай танилцдаг, шүүх хуралдаанд бэлтгэл муутай оролцдог.
- Өмгөөлөгч нар ялагч буюу мэтгэлцэгч талаас асуулт асуух зэргээр мэтгэлцдэггүй.
- Өмгөөлөгч мэтгэлцээнд идэвхигүй оролцож, шүүгдэгчийн хууль ёсны ашиг сонирхлыг бүрэн гүйцэд хамгаалж чаддаггүй.
- Асуултаа тодорхой, оновчтой тавьж чаддаггүй.
- Төлбөрийн чадваргүй иргэдийг өмгөөлөхөөр томилогдсон өмгөөлөгч нарын идэвхи сул байна.

Өмгөөлөгчдийн дунд шүүх хуралдаанд хангалттай бэлтгэдэггүй, мэтгэлцээнд идэвхитэй байр сууринаас оролцдоггүй байдал ажиглагдлаа. Өмгөөлөгч шүүгдэгчийн хувийн байдлыг харгалзан үзнэ үү, шүүгдэгчийг “ядуу юм”, “өвчтэй юм”, “хөгшин эцэг эхийг нь харж хандах хүнгүй юм”, “нялх хүүхэдтэй юм” гэх мэт төдийлөн ач холбогдол багатай саналуудыг шүүмжлэлийн шатанд тавьж харин хууль зүйн хувьд ямар дүгнэлт өгч байгаа, зүйл анги таарч байгаа эсэх зэрэг дээр оновчтой, тодорхой санал хэлэхгүй “хуульд заасан хөнгөн ял оногдуулж өгнө үү” гэх мэтээр аргацаасан шинжтэй өмгөөлөл явуулж байлаа. Энэ нь нотлох баримтыг анхнаасаа яллах талыг барьж

бүрдүүлсэнтэй холбоотой юм. Хавтаст хэрэгт цагаатгах талын баримт ховор байдаг нь өмгөөлөгч нарт бодитой бэрхшээл учруулдаг байна. Ялангуяа шүүхийн өмнөх шатанд өмгөөлөгч ажиллаагүй хэрэгт ийм байдал илүү ажиглагдаж байлаа. Энэ тохиолдолд хэрэв хохирлоо төлсөн бол энэ баримтыг нь, бие нь муу өвчтэй бол эмнэлгийн бичиг, ял эдэлж байгаагүй бол ял шалгах хуудсаа, ажлынх нь хамт олны тодорхойлолт, нэн ядуу төлбөрийн чадваргүй үед хорооны засаг даргын тодорхойлолт гэх мэт тоймтой хэдэн баримтыг л шинжлэн судлахад хүрдэг. Гэхдээ өмгөөлөгчид энэ байдлаас гарах гарц олж өмгөөллөө чанартай явуулахад одоогийнхоос илүү ур чадвар шаардагдана.

Өмгөөлөгчид хугацаагаа барихгүй, хоцорч ирснээр шүүгчдэд зэмлүүлэх ийм байдлаар нэгэнт үнэлэмж нь буурсан тул өмгөөлөгчийн үгийг шүүгч нар үл тоох байдал гарч байна. Түүчлэн өөрт ашигтай асуулт тавьж мэдүүлэг авах өмгөөлөгчийн чадвар хангалтгүй байх тохиолдол ч гарч байлаа. Тухайлбал, та өөрийн үйлдэлдээ ямар үнэлэлт өгч байна, хохирлоо төлсөн үү, хохирогчоосоо уучлал гуйсан уу, өөр үйлдсэн хэрэг байна уу, үйлдлээсээ зөвшөөрөхгүй гэж байгаа үйлдэл байна уу гэх мэт зарим талаар яллагчийн асуултыг ч тавьж байсныг хэлэх хэрэгтэй.

Мөн шүүх хуралдааны явцад өмгөөлөгч өөрийн үйл хөдлөл, биеэ авч явах байдалдаа хяналт тавьдаггүй зэрэг дутагдал ажиглагдаж байна.

Өмгөөлөгчдийн тухайд дээр дурдсан алдаа дутагдалд онцгой анхаарч цаашид Монголын Өмгөөлөгчдийн Холбооноос өмгөөлөгчдийн эрүүгийн хэрэгт өмгөөлөл явуулах мэргэжлийн ур чадвар, ёс зүйн стандартыг дээшлүүлэх арга хэмжээ авна хэмээн найдаж байна. Түүнчлэн хувь өмгөөлөгч бүр үйл ажиллагаандаа ийм зөрчил, алдаа дутагдлыг гаргахгүйг хичээн ажиллах нь зүйтэй юм.

2.2.4. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга

► Хуулийн үндэслэл

ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 73 дугаар зүйлийн 73.1-д шүүгчээс шүүн таслах ажиллагаагаа хэрэгжүүлэхэд шаардлагатай техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, хэрэг, маргааны талаар судалгаа хийж танилцуулах, хуульд заасан бусад үүрэг бүхий “... шүүгчийн туслахтай байх”, мөн хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1-д “бүх шатны шүүхэд шүүх хуралдааны нарийн бичгийн дарга ажиллах” ёстой гэж тус тус заажээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 253 дугаар зүйлийн 253.1-д зааснаар шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нь шүүх хуралдааны үед тэмдэглэл үйлдэх үүрэгтэй.

► Ажиглалтын дүн

Шүүх хуралдааны тэмдэглэл үйлдэх ажиллагаа нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нэг чухал хэсэг бөгөөд шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нь хуульд заасан шаардлагын дагуу тэмдэглэлийг бүрэн, зөв хянуур хөтлөх ёстой.

№	Шүүхийн нэр	Шүүх хуралдааны нарийн бичгийн даргын оролцооны талаарх үнэлгээ
1	Баянгол дүүргийн шүүх	45.7 хувьд нь шүүх хуралдааны тэмдэглэлийг компьютерт шивж, 11.4 хувьд нь гараар бичиж хөтөлсөн.
2	Баянзүрх дүүргийн шүүх	83.7 хувьд нь шүүх хуралдааны тэмдэглэлийг компьютерт шивж хөтөлсөн бөгөөд шүүх хуралдааны явц бүрийг нэг бүрчлэн бичихгүй байх, бохь заглах, албан ёсны бус, тохиромжгүй хувцаслалттай шүүх хуралдаанд оролцох зэрэг дутагдалтай тал ажиглагдлаа.
3	Сүхбаатар дүүргийн шүүх	63.6 хувьд нь шүүх хуралдааны тэмдэглэлийг компьютерт шивж хөтөлсөн.
4	Сонгинохайрхан дүүргийн шүүх	67.9 хувьд нь шүүх хуралдааны тэмдэглэлийг компьютерт шивж хөтөлсөн. Мөн аудио бичлэг ашиглан тэмдэглэл хөтөлж байсан.
5	Хан-Уул дүүргийн шүүх	74.2 хувьд нь шүүх хуралдааны тэмдэглэлийг компьютерт шивж хөтөлсөн. Нарийн бичгийн дарга нарын иргэдтэй харилцах харилцаа тааруу. Хурал хойшилсон шалтгааныг асуухад уурлаж, мэдээлэл өгөхгүй байх тохиодол гарсан.
6	Чингэлтэй дүүргийн шүүх	64.5 хувьд нь шүүх хуралдааны тэмдэглэлийг компьютерт шивж хөтөлсөн. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хуралдааны завсарлагаагаар гарч явснаас шүүхийн шийдвэр уншиж сонгоход түүнийг 10 минут хүлээж, улмаар түүнийг байлцуулахгүйгээр шийдвэрийг уншиж сонгосон тохиолдол гарлаа.
7	Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх	71.4 хувьд нь шүүх хуралдааны тэмдэглэлийг компьютерт шивж хөтөлсөн.
8	Дорнод аймаг дахь Сум дундын I шүүх	80 хувьд нь шүүх хуралдааны тэмдэглэлийг компьютерт шивж хөтөлсөн.
9	Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүх	89.5 хувьд нь шүүх хуралдааны тэмдэглэлийг компьютерт шивж хөтөлсөн.

Ажиглалтаас харахад шүүхийн нарийн бичгийн даргын оролцоо идэвхигүй сул, зарим тохиодолд шүүх хурлын тэмдэглэлийг бүрэн хөтлөхгүй байгаа нь оролцогчид болон ажиглагчдад шүүхийн тэмдэглэл бүрэн, үнэн зөв тэмдэглэгддэг эсэхэд эргэлзээ төрүүлж байна. Түүнчлэн шүүхийн нарийн бичгийн дарга нь шүүхийн ажилтны хувиар шүүгчийн адил биеэ авч явах байдалдаа онцгой анхаарч шүүх хуралдаанд хүндэтгэлтэй хандах хэрэгтэй.

Шүүх хуралдааны танхимд тэмдэглэл хөтлөх зориулалт бүхий компьютер байрлуулж түүнд хурлын тэмдэглэлийг шивж хөтөлж буй нь сайшаалтай. Гэвч цөөн тохиолдолд шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хуралдааны явц бүрийг бүрэн, зөв хянуур хөтлөх үүргээ үл биелүүлэх нь ажиглагдав. Мөн нарийн бичгийн дарга нарын бусадтай харилцах харилцаа болон хувцаслалт нь шүүхийн нэр хүнд, итгэл, хүндлэл төрүүлэхүйц байдалд нөлөөлж буйг анхаарахгүй байж болохгүй юм.

2.2.5. Орчуулагч, хэлмэрч

► Хуулийн үндэслэл

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛИЙН 19 дүгээр зүйлийн 19.2-т “байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч этгээд нь монгол хэл мэддэггүй бол өөрийн эх буюу мэддэг хэлээр, бичгээр, хараагүй, хэлгүй, дүлий этгээд дохио, зангаа, тусгай тэмдэгт ашиглан орчуулагч, хэлмэрчийн тусламжтайгаар мэдүүлэг өгөх, гомдол гаргах, шүүх хуралдаанд үг хэлэх, хэргийн холбогдох бүх материалтай бүрэн танилцах эрхээр хангагдана”, 47 дугаар зүйлийн 47.1-д “энэ хуулийн 19.2-т заасан тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь орчуулга хийх, хэлмэрчлэх мэдлэг, чадвартай хүнийг орчуулагч, хэлмэрчээр томилох тухай шийдвэр гаргаж уг этгээдэд танилцуулна”, 47.2-т “орчуулагч, хэлмэрч нь дуудсан цагт ирж орчуулах, хэлмэрчлэхээр даалгасан үүргийг бүрэн, зөв биелүүлэх үүрэгтэй” гэж тус тус заажээ. Мөн хуулийн 256 дугаар зүйлийн 256.1-д зааснаар орчуулагч, хэлмэрч нь хуралдаанд оролцож байгаа монгол хэл мэддэггүй, эсхүл хэлгүй, дүлий хүний мэдүүлэг, хүсэлтийг шүүхэд; шүүх хуралдаан дээр гарсан мэдүүлэг, хүсэлт, уншсан баримт бичиг, түүнчлэн шүүх хуралдаан даргалагчийн болон оролцогчдод орчуулж, хэлмэрчилж өгөх үүрэгтэй болохыг шүүх хуралдаан даргалагч түүнд тайлбарлаж өгнө. Мөн санаатайгаар худал орчуулах буюу хэлмэрчилбэл хуульд заасан хариуцлага хүлээлгэхийг орчуулагч, хэлмэрчид урьдчилан сануулж, шүүх хуралдааны тэмдэглэлд гарын үсэг зуруулах ёстой.

► Ажиглалтын дүн

Орчуулагч, хэлмэрчийн оролцоог дараах хүснэгтээс харна уу.

№	Шүүхийн нэр	Орчуулагч, хэлмэрчийн оролцоо	Шүүгдэгчийн орчуулагч, хэлмэрч авах хүсэлт гаргах эрх, түүнийг хангаж буй байдал
1	Баянгол дүүргийн шүүх	28.6 хувьд нь орчуулагч, хэлмэрч авах эрхийг тайлбарласан. Хууль зүйн яамнаас томилсон орчуулагч нь тухайн шүүх хуралд ирээгүй.	10 хувьд нь орчуулагч /хэлмэрч/ авах хүсэлт гаргаж, хүсэлтийг мөн хувиар хангасан ба нийт ажиглалтын 2 буюу 5.7 хувьд нь дохион хэлний хэлмэрч оролцжээ.
2	Баянзүрх дүүргийн шүүх	48.8 хувьд нь орчуулагч, хэлмэрч авах эрхийг тайлбарласан	3.4 хувьд нь орчуулагч /хэлмэрч/ авах хүсэлт гаргаж, хүсэлтийг мөн хувиар хангасан байна.
3	Сүхбаатар дүүргийн шүүх	41.9 хувьд нь орчуулагч, хэлмэрч авах эрхийг тайлбарласан байна.	3.6 хувьд нь орчуулагч /хэлмэрч/ авах хүсэлт гаргасан ба ажиглалтын 2.3 хувьд дохион хэлний хэлмэрч оролцжээ.

№	Шүүхийн нэр	Орчуулагч, хэлмэрчийн оролцооны талаарх үнэлгээ	Шүүгдэгчийн орчуулагч, хэлмэрч авах хүсэлт гаргах эрх, түүнийг хангаж буй байдал
4	Сонгинохайрхан дүүргийн шүүх	60,6 хувьд хэлмэрч орчуулагч авах эрхийг тайлбарласан боловч нэг тохиолдолд шүүх хуралдаанд оролцсон хэлгүй, дүлий оролцогч хэлмэрч оролцуулах эрхийг тайлбарлаагүй шүүгдэгч шүүх хуралдааны явцыг төдийгүй шүүхийн шийдвэрийг ойлгоогүй явдал гарлаа.	4.9 хувьд нь орчуулагч /хэлмэрч/ авах хүсэлт гаргаж, хүсэлтийг мөн хувиар хангасан ба нийт ажиглалтын 1 буюу 4.2 хувьд нь дохион хэлний хэлмэрч оролцжээ.
5	Хан-Уул дүүргийн шүүх	48.4 хувьд нь орчуулагч, хэлмэрч авах эрхийг тайлбарласан.	Орчуулагч, хэлмэрч авах хүсэлт гаргаагүй
6	Чингэлтэй дүүргийн шүүх	22.6 хувьд нь орчуулагч, хэлмэрч авах эрхийг тайлбарласан	Орчуулагч, хэлмэрч авах хүсэлт гаргаагүй
7	Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх	100 хувьд нь орчуулагч, хэлмэрч авах эрхийг тайлбарласан байна.	Орчуулагч, хэлмэрч авах хүсэлт гаргаагүй
8	Дорнод аймаг дахь Сум дундын I шүүх	25 хувьд нь орчуулагч, хэлмэрч авах эрхийг тайлбарласан.	Орчуулагч, хэлмэрч авах хүсэлт гаргаагүй
9	Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүх	37.5 хувьд нь орчуулагч, хэлмэрч авах эрхийг тайлбарласан.	Орчуулагч, хэлмэрч авах хүсэлт гаргаагүй

Ажиглалтаас харахад орчуулагч, хэлмэрч авах эрхийг алдаг оног тайлбарладаг нь харагдаж байна. Хэдийгээр шүүгдэгч, хохирогчдын хөгжлийн бэрхшээл болон монгол хэлний мэдлэг тодорхойлогдсон байдаг ч ажиглалтад хамрагдсан шүүх хуралдааны нэгд нь орчуулагч авах, бас нэг тохиолдолд хэлмэрч авах шаардлагатай этгээд оролцсон байх ба хэлмэрч авах этгээдэд эрхийг нь тайлбарлаагүйн улмаас хэлгүй, дүлий оролцогч хэлмэрчгүйгээр шүүх хуралдаанд оролцож, улмаар шүүх хуралдааны явцыг төдийгүй шүүхийн шийдвэрийг ч ойлгоогүй ноцтой тохиолдол гарсан байна. Мөн түүнчлэн Сүхбаатар дүүргийн шүүхийн эрүүгийн шүүх хуралдаанд “сонгол муутай” хэлмэрч оролцжээ.

Орчуулагч, ялангуяа хэлмэрч оролцуулах тохиолдолд хуулиар хүлээсэн үүргээ хангалттай гүйцэтгэж чадахуйц этгээдийг сонгож томилох асуудалд шүүгчид хариуцлагатай ханддаг болох хэрэгтэй байна.

2.2.6. Хохирогч

► Хуулийн үндэслэл

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛИЙН 42 дугаар зүйлийн 42.1-д “гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэнэ” хэмээн тодорхойлж, мөн зүйлийн 42.3-т хохирогч, түүний төлөөлөгч нь өмгөөлөгч авах, баримт сэлт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах, шүүх хуралдаанд оролцох, шүүгдэгч, гэрч, шинжээчид асуулт тавих, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах, эх хэлээрээ болон мэддэг хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа дууссаны дараа хэргийн бүх материалтай танилцах, гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, цагаатгах буюу шийтгэх тогтоолын хувийг авах, түүнд давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй болохыг заасан байна.

► Ажиглалтын дүн

Хохирогчийн оролцооны хувийг доорх хүснэгтээс харна уу.

№	Шүүхийн нэр	Хохирогчийн оролцооны талаарх үнэлгээ
1	Баянгол дүүргийн шүүх	34.3 хувьд нь хохирогч оролцож, үүний 60 хувьд нь хохирогчийн өмгөөлөгч оролцсон байна.
2	Баянзүрх дүүргийн шүүх	46.5 хувьд нь хохирогч оролцож, 11.6 хувьд нь шүүх хуралдаанд хохирогчийн өмгөөлөгч оролцсон байна.
3	Сүхбаатар дүүргийн шүүх	40 хувьд нь хохирогч оролцож, 13.5 хувьд нь шүүх хуралдаанд хохирогчийн өмгөөлөгч оролцсон байна.
4	Сонгинохайрхан дүүргийн шүүх	30.4 хувьд нь хохирогч оролцож, 11.9 хувьд нь шүүх хуралдаанд хохирогчийн өмгөөлөгч оролцсон байна.
5	Хан-Уул дүүргийн шүүх	45.2 хувьд нь хохирогч оролцож, 16.1 хувьд нь шүүх хуралдаанд хохирогчийн өмгөөлөгч оролцсон байна.
6	Чингэлтэй дүүргийн шүүх	38.7 хувьд нь хохирогч оролцож, 48.4 хувьд нь шүүх хуралдаанд хохирогчийн өмгөөлөгч оролцсон байна.
7	Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх	50 хувьд нь хохирогч оролцож, 28.6 хувьд нь шүүх хуралдаанд хохирогчийн өмгөөлөгч оролцсон байна.
8	Дорнод аймаг дахь Сум дундын I шүүх	Бүх шүүх хуралдаанд хохирогч оролцож, 11.1 хувьд нь шүүх хуралдаанд хохирогчийн өмгөөлөгч оролцсон байна.
9	Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүх	18.2 хувьд нь хохирогч оролцож, 27.3 хувьд нь шүүх хуралдаанд хохирогчийн өмгөөлөгч оролцсон байна.

Ажиглалтаар хохирогч шүүх хуралдаанд тэр бүр оролцдоггүй, улмаар өмгөөлөгч авдаггүй байдал нэлээд элбэг байна. Иймд хохирогчдын шүүх хуралдаанд оролцохгүй, өмгөөлөгч авахгүй байгаа шалтгааныг судлах зайлшгүй шаардлага гарч байна.

2.2.7. Гэрч

▶ Хуулийн үндэслэл

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛИЙН 45 дугаар зүйлийн 45.1-д “хэргийн талаар ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа, тухайн хэрэгт холбогдолгүй хүнийг гэрч гэнэ”, 45.2-т “гэрчийг энэ хуулийн 143 дугаар зүйлд заасан журмаар дуудаж байцаана” гэж заасан.

▶ Ажиглалтын дүн

Мэтгэлцээний талууд /цагаатгах ба яллах/ шүүх хуралдаанд өөрийн байр суурийг нотлох гэрчийг оролцуулах эрхтэй. Өнөөдөр Монгол Улсад эрүүгийн хэргийг нотлох үндсэн элемент нь гэрч, хохирогчийн мэдүүлэг юм. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хэргийг байцаалтын аргаар нотолж байна. Гэтэл шүүхийн ажиглалтаар шүүх хуралдаанд яллах талын гэрч л оролцож байгаа бөгөөд цагаатгах талын гэрч оролцсон маш цөөхөн тохиолдол байна. Энэ нь мэтгэлцээний талуудын харилцан адилгүй байдалтай холбоотой. Учир нь өнөөгийн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зохицуулалт яллах талд давуу байдал олгосон. Өөрөөр хэлбэл, яллах тал буюу прокурор хэрэг үүсэхээс эхлээд яллах талын нотлох баримтыг бүрдүүлэхэд оролцоор ирдэг бол өмгөөлөгч мөрдөн байцаалтын ажиллагаа дууссанаар л хэргийн материалтай танилцах эрхтэй болдог. Ийм учраас хэрэгт ихэнхдээ яллах талын цуглуулсан баримтууд байдаг байна. Мөн нөгөө талаар, мэтгэлцээний талууд гэрчийг оролцуулах эрхээ эдэлж, түүний мэдүүлгийг үндэслэл болгон мэтгэлцэх боломжоо ашиглахгүй, мэтгэлцээний талаарх хуулийн заалтуудыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэхгүй байгаа бөгөөд энэ тэдний мэтгэлцэх ур чадвар дутсантай холбоотой гэж дүгнэхэд хүрлээ.

№	Шүүхийн нэр	Гэрчийн оролцооны талаарх үнэлгээ
1	Баянгол дүүргийн шүүх	14.3 хувьд нь яллах талын, 8.6 хувьд нь цагаатгах талын гэрч шүүх хуралдаанд оролцсон байна. Гэрчтэй холбоо барьж чадаагүйн улмаас гэрч шүүх хуралдаанд ирээгүй, хэргийн газар дээр байсан, хэргийн талаар сайн мэдэх гэрчийг шүүх хуралдаанд оролцуулаагүй, шүүх хуралдаанд хэргийн талаар бараг мэдэхгүй хүнийг гэрчээр дуудаж оролцуулсан, яллах болон цагаатгах талын гэрчийн мэдүүлэг зөрсөн бөгөөд хэргийн газар дээр байсан, хэргийн бодит байдлыг мэдэж байгаа гэрчийг байцаалгаж мөрдөн байцаалтад буцаах тухай өмгөөлөгчийн саналыг хүлээж аваагүй зэрэг тохиолдууд гарсан байна.
2	Баянзүрх дүүргийн шүүх	9.3 хувьд нь яллах талын гэрч оролцож цагаатгах талын гэрч оролцоогүй байна.
3	Сүхбаатар дүүргийн шүүх	4.5 хувьд нь яллах талын гэрч оролцож цагаатгах талын гэрч оролцоогүй байна.
4	Сонгинохайрхан дүүргийн шүүх	42.8 хувьд нь яллах талын гэрч оролцож цагаатгах талын гэрч оролцоогүй байна.
5	Хан-Уул дүүргийн шүүх	9.7 хувьд нь яллах талын гэрч оролцож цагаатгах талын гэрч оролцоогүй байна.

№	Шүүхийн нэр	Гэрчийн оролцооны талаарх үнэлгээ
6	Чингэлтэй дүүргийн шүүх	9.7 хувьд нь яллах талын гэрч оролцож цагаатгах талын гэрч оролцоогүй байна.
7	Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх	28.6 хувьд нь яллах талын гэрч оролцож цагаатгах талын гэрч оролцоогүй байна.
8	Дорнод аймаг дахь Сум дундын I шүүх	40 хувьд нь яллах талын, 20 хувьд нь цагаатгах талын гэрч шүүх хуралдаанд оролцсон байна.
9	Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүх	4.3 хувьд нь яллах талын гэрч оролцож цагаатгах талын гэрч оролцоогүй байна.

2.2.8. Иргэдийн төлөөлөгч

► Хуулийн үндэслэл

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛИЙН 34 дүгээр зүйлийн 34.1-д “иргэдийн төлөөлөгч нь шүүхийн хэлэлцүүлгийн үед оролцогчид асуулт тавих эрхтэй бөгөөд нотлох баримтыг судалж үнэлсний үндсэн дээр шүүгдэгчийн гэм буруугийн талаар саналаа бичгээр гаргах эрхтэй. Иргэдийн төлөөлөгч саналаа шүүх хуралдаанд уншиж сонсгож болно”, 34.2-т “шүүх анхан шатны журмаар хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэхэд 3 иргэдийн төлөөлөгчийг оролцуулна”, мөн хуулийн 261 дүгээр зүйлийн 261.3-т “шүүгч, иргэдийн төлөөлөгч нотлох баримтыг шинжлэхэд оролцож, аль ч үед тодруулах асуулт тавих эрхтэй” гэж тус тус заажээ.

► Ажиглалтын дүн

Иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд ямар нэг үүрэггүй оролцож байгаа нь ажиглагдлаа. Тэд хуульд заасны дагуу нотлох баримт шинжлэхэд оролцох, тодруулах асуулт тавих эрхтэй боловч нотлох баримт шинжлэхэд оролцохгүй, харин ганц нэг асуулт тавих замаар үүргээ хэрэгжүүлж байлаа. Ийм учраас иргэдийн төлөөлөгчидийн одоогийн оролцоог өөрчлөх, идэвхийг сайжруулах талаар холбогдох судалгаа хийх шаардлагатай байна.

№	Шүүхийн нэр	Иргэдийн төлөөлөгчийн оролцооны талаарх үнэлгээ
1	Баянгол дүүргийн шүүх	Шүүх хуралдаанд өндөр настай 3 иргэн иргэдийн төлөөлөгчөөр оролцсон ба 2 нь шүүх хуралдааны явцад унтах, иргэдийн төлөөлөгчид шүүх хуралдааны дундуур орж гарч, юм идэх зэрэг тохиолдол гарсан.
2	Баянзүрх дүүргийн шүүх	Иргэдийн төлөөлөгчид шүүх хуралдааны явцад нэг ч үг дуугараагүй, идэвхигүй, хүндэтгэл төрүүлэхүйц байгаагүй, шүүхийн цэвэрлэгч иргэдийн төлөөлөгчөөр шүүх хуралдаанд оролцсон, иргэдийн төлөөлөгч шүүх хуралдааны дундуур хуралдаанд орж ирэх тохиолдлууд ажиглагдлаа.

3	Сүхбаатар дүүргийн шүүх	Иргэдийн төлөөлөгчдийн санал шүүхийн шийдвэрт төдийлөн нөлөөлдөггүй; эрх зүйн мэдлэг муутайн улмаас нотлох баримт шинжлэхэд оролцохгүй, асуулт асуухгүй, шүүгч нарын аяыг харсан, цаг нөхцөөсөн байдалтай байв.
4	Сонгинохайрхан дүүргийн шүүх	Иргэдийн төлөөлөгчдийн санал шүүхийн шийдвэрт төдийлөн нөлөөлдөггүй, эрх зүйн мэдлэг муутайн улмаас нотлох баримт шинжлэхэд оролцохгүй, асуулт асуухгүй, шүүгч нарын аяыг харсан, цаг нөхцөөсөн байдалтай байсан.
5	Хан-Уул дүүргийн шүүх	Иргэдийн төлөөлөгчдийн оролцоо бага, идэвхигүй.
6	Чингэлтэй дүүргийн шүүх	Шүүх хуралдааны явцад шүүгч ширээн дээр асгасан усаа иргэдийн төлөөлөгчөөр арчуулсан нь хүндэтгэлгүй санагдсан бөгөөд иргэдийн төлөөлөгчид хуралдаан дээр унтсан, залхсан шинжтэй байсан.
7	Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх	Иргэдийн төлөөлөгчдийн оролцоо бага, идэвхигүй.
8	Дорнод аймаг дахь Сум дундын I шүүх	Иргэдийн төлөөлөгчдийн оролцоо бага, идэвхигүй.
9	Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүх	Иргэдийн төлөөлөгч шүүх хуралдааны туршид бохь зажилж байсан нь зохимжгүй байсан бөгөөд ажиглалтын явцад тодорхой 3 хүн л иргэдийн төлөөлөгчөөр тогтмол оролцов.

2.3. Шүүхийн цаг барилт, дэг журам хангагдаж буй байдал

2.3.1. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явагдсан хугацаа

► Хуулийн үндэслэл




ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛИЙН 178 дугаар зүйлийн 178.1-д “хэрэг бүртгэлт явуулах үндсэн хугацаа эрүүгийн хэрэг үүсгэснээс хойш 21 хоног байна”, мөн зүйлийн 178.2-т “хэрэг бүртгэлтийн нэмэлт ажиллагаа хийх зайлшгүй шаардлага гарвал прокурор хэргийн хугацааг тухай бүрт нь 15 хүртэл хоногоор сунгана”, 182 дугаар зүйлийн 182.1-д “мөрдөн байцаалт явуулах үндсэн хугацаа эрүүгийн хэрэг үүсгэснээс хойш 2 сар байна”, 182.4-т мөрдөн байцаалтын хугацааг сунгах асуудлыг, мөн хуулийн 215 дугаар зүйлийн 215.1-д “хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэргийг прокурор 14 хоногийн дотор хянах ба зайлшгүй тохиолдолд зохих дээд шатны прокурор энэхүү хугацааг 14 хүртэл хоногоор нэмж сунгаж болно”, 225 дугаар зүйлийн 225.3-т “захирамжийг хэрэг шүүхэд ирснээс хойш 15 хоногийн дотор гаргана”, 233 дугаар зүйлийн 233.1-д “яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай шүүгчийн захирамж гарсан өдрөөс эхлэн 10 хоногоос хэтрүүлэхгүйгээр хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэж эхэлнэ” гэж эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хугацааг тус тус зааж өгчээ.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь тодорхой хугацаанд эхэлж дуусах ёстой. Тухайлбал, яллагдагч тал шүүх хуралдаанд бэлтгэхэд зохих ёсны хугацаа, хэрэгслээр хангагдаж, байцаан шийтгэх ажиллагаа тодорхой хугацаанд эхэлж, ямар нэгэн хүндэтгэх шалтгаангүйгээр хойшлуулалгүйгээр эцсийн шатны шүүхийн шийдвэр хугацаандаа гарах ёстой. Хэрэг шийдвэрлэлтийг түргэсгэх үүрэг нь аливаа хүнийг эрүүгийн хэрэгт татан, урьдчилан хорьсон нөхцөлд илүү анхаарал тавин хэрэгжиж, аль болох богино хугацаанд шүүн таслах ажиллагааг явуулах шаардлагатай. Хэрэв байцаан шийтгэх ажиллагаанд боломжтой гэж үзсэн хугацааг сунгавал эрүүгийн хэрэгт татагдан урьдчилан хоригдсон хүнийг суллахыг олон улсын стандарт шаарддаг. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа шуурхай явагдах баталгаа нь эрх чөлөөтэй байх эрх, гэм буруугүйд тооцогдох эрх, өөрийгөө хамгаалах эрхүүдтэй холбогддог. Энэ нь яллагдагчийн хувь заяаг удаалгүйгээр шийднэ гэсэн үг.


► Ажиглалтын дүн

Ажиглалтад хамрагдсан эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хугацааг доорх графикаар үзүүллээ. Ингэхдээ тухайн эрүүгийн хэрэг нээгдсэн цагаас тооцож гаргасан бөгөөд үзүүлэлтийн хувьд тухайн хэргийн хүнд хөнгөнөөс хамааран янз бүр байна.


Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явагдсан хугацаа




Сонгино хайрхан дүүргийн шүүх




Хан-Уул дүүргийн шүүх




Чингэлтэй дүүргийн шүүх




Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх



Дорнод аймаг дахь Сум дундын шүүх



Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүх



Ажиглалтад хамрагдсан нийт хэргийн 40.9 хувьд 6 сар, түүнээс дээш хугацаанд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулдаг байна. Энэ нь хэдийгээр хуульд заасан ЭБША явуулах үндсэн хугацаанаас илүү байгаа ч хуулийн дагуу сунгагдах хугацаагаар тооцвол хууль зөрчөөгүй юм. Гэхдээ судлагдсан хэргийн хүнд, хөнгөн, ээдрээ түвэгтэй байдалтай харьцуулан байцаан шийтгэх ажиллагаа явагдсан хугацаанд дүгнэлт өгөх нь зүйтэй.

ЭБША-г аль болох боломжтой богино хугацаанд явуулах талаар байцаан шийтгэх ажиллагааны шаг бүрт анхаарч, тухайн орон нутаг, дүүргийн хэмжээнд байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчдийн нэгдсэн хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулах замаар уг асуудлыг шийдвэрлэх боломжтой.

2.3.2. Шүүх хуралдаан товлосон цагтаа эхэлж буй байдал

► *Хуулийн үндэслэл*

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛИЙН 228 дугаар зүйлийн 228.1-д “шүүгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд энэ хуульд заасан байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдын эрхийг бүрэн хангасан, шүүх хуралдаанаар хэргийг хянан шийдвэрлэхэд саад болох зүйл байхгүй гэж үзвэл яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай захирамж гаргаж, шүүх хуралдааны товыг зарлана”, 232 дугаар зүйлийн 232.1-д “яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай захирамжид заасан оролцогчийг шүүх хуралдаанд дуудан ирүүлэх, шүүх хуралдаанд бэлтгэх бусад арга хэмжээг шүүх хуралдааны нарийн бичгийн дарга гүйцэтгэнэ”, мөн зүйлийн 232.3-т “цагдан хоригдож байгаа шүүгдэгчийг товлосон хугацаанд шүүхэд ирүүлэхийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хариуцна” гэж тус тус заасан нь шүүх хуралдааныг товлон зарлах, уг хугацаанд шүүх хуралдааныг эхлүүлэх асуудлыг зохицуулсан байна.

► *Ажиглалтын дүн*

Шүүхийн цаг барилт ба зохион байгуулалтад өгсөн үнэлгээг дараах хүснэгтэд харуулав.

№	Шүүхийн нэр	Шүүх хуралдаан товлосон цагтаа эхлээгүй тохиолдол, шалтгаан
1	Баянгол дүүргийн шүүх	<ul style="list-style-type: none"> • 9.00 цагийн шүүх хуралдаанд 9.00 цагт очиход “болоогүй байна” хэмээн оруулахгүй, шүүхийн гадаа хүлээв. • Шүүх хуралдааны товын дагуу 12.30 цагт эхлэх хуралдаан “өмнөх шүүх хуралдаан удааширсан”-ы улмаас 13.20 цагт эхэлсэн. Мөн 14.00 цагт эхлэх хуралдаан 15.00 цагт эхэлсэн. • Мөн шүүх хуралдааны оролцогч нар цагтаа ирэхгүй байх, шүүгч цагаа баримтлахгүй байх зэрэг шалтгаанаар хуралдаан товлосон цагтаа эхлээгүй. • Ер нь өдрийн эхний хуралдаан тухайлбал, 9.00 цаг, 14.00 цагийн хуралдаан цагтаа эхлээгүйгээс дараагийн шүүх хуралдаан хойшилдог.

№	Шүүхийн нэр	Шүүх хуралдаан товлосон цагтаа эхлээгүй тохиолдол, шалтгаан
2	Баянзүрх дүүргийн шүүх	<ul style="list-style-type: none"> • Шүүх хуралдаан өмнөх хуралдаан дуусаагүй; цагдан хоригдож байгаа шүүгдэгчийг шүүх хуралдаанд товлосон цагт авч ирээгүй; шүүх хуралдааны оролцогч нар хоцорч ирсэн гэсэн шалтгаанаар хоцорч эхэлсэн тохиолдол гарсан. • Хохирогч цагаа андуурснаас болж шүүх хуралдаан бүтэн 1 цагийн дараа эхэлсэн. • 9.00, 14.00 цагийн шүүх хуралдаан шүүгч, улсын яллагч, бусад оролцогчдын цаг баримтлалаас шалтгаалан байнга хоцорч эхэлдэг. • Шүүх бүрэлдэхүүн улсын яллагчийг бүтэн 2 цаг хүлээсэн.
3	Сүхбаатар дүүргийн шүүх	<ul style="list-style-type: none"> • Нийт ажигласан шүүх хуралдаанаас ердөө 3 шүүх хуралдаан л цагтаа эхэлсэн бол 2 шүүх хуралдаан 2 болон 2,5 цаг хоцорч эхэлж байжээ. • Шүүгч нар шүүгчдийн зөвлөгөөнтэй гэх шалтгаанаар хуралдаан товлосон цагтаа эхэлдэггүй. • Өмгөөлөгч нар шүүх хуралдаанаас хоцорсон. • Цагдан хоригдож буй этгээдийг авчрахдаа хоцроох. • Шүүх хуралдаанд оролцох улсын яллагч давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцсоноос хоцрох асуудал нэлээд гарч байна.
4	Сонгинохайрхан дүүргийн шүүх	<ul style="list-style-type: none"> • Цагтаа эхэлсэн ердөө 4 шүүх хуралдаан байсан бол 1- 2,5 цаг хоцорч эхэлсэн 10 шүүх хуралдаан байна. • Шүүгч, өмгөөлөгчийн цагт барилт. • Хорих 461 дүгээр ангиас нэг машинаар тухай өдөр шүүх хуралдаанд оролцох шүүгдэгч нарыг ачиж, шүүхүүдэд хүргэдэг ба тус шүүхэд хамгийн сүүлд хүргэдгээс шалтгаалан шүүх хуралдаан цагтаа эхэлдэггүй.
5	Хан-Уул дүүргийн шүүх	<ul style="list-style-type: none"> • Шүүх хуралдаан өмнөх хуралдаан дуусаагүй; цагдан хоригдож байгаа шүүгдэгчийг шүүх хуралдаан товлосон цагт авч ирээгүй; шүүх хуралдааны оролцогч нар хоцорч ирсэн гэсэн шалтгаанаар хоцорч эхэлсэн тохиолдол гарсан. • Эхний буюу 9.00, 14.00 цагийн хуралдаан цагтаа эхэлдэггүй.
6	Чингэлтэй дүүргийн шүүх	<ul style="list-style-type: none"> • Шүүх хуралдаан өмнөх хуралдаан дуусаагүй; цагдан хоригдож байгаа шүүгдэгчийг шүүх хуралдаан товлосон цагт авч ирээгүй; шүүх хуралдааны оролцогч нар хоцорч ирсэн гэсэн шалтгаанаар хоцорч эхэлсэн тохиолдол гарсан. • Эхний буюу 9.00, 14.00 цагийн хуралдаан цагтаа эхэлдэггүй.
7	Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх	<ul style="list-style-type: none"> • Шүүх хуралдааны танхим хүрэлцээгүйн улмаас шүүх хуралдаан цагтаа эхлээгүй. • Зарим шүүх хуралдааны товлосон цагийг тодорхой мэдэх боломжгүй байсан тул цагтаа эхэлж байсан эсэхийг тодорхойлох боломжгүй байсан.
8	Дорнод аймаг дахь Сум дундын I шүүх	<ul style="list-style-type: none"> • Шүүх хуралдааны цаг барилт харьцангуй сайн байсан.
9	Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүх	<ul style="list-style-type: none"> • Цагтаа эхэлсэн 1, харин 1-2,5 цаг хоцорч эхэлсэн 5 шүүх хуралдаан байна. Мөн 1 шүүх хурал товлосон цагаасаа өмнө эхэлсэн байна. • Шүүх хуралдаанд оролцогчийн цагт барилт. • Өмгөөлөгч, улсын яллагч нар шүүхийн шийдвэрийг сонсох үед хоцордог. Өөрөөр хэлбэл, хуралдаан завсарласны дараа шүүхийн шийдвэр сонсоход удах, бүр ирэхгүй байх тохиолдол байна.

Шүүх хуралдаан товлосон цагтаа эхлэхгүй байгаа нь шүүгч болон шүүх хуралдааны бусад оролцогчдын ажлын зохион байгуулалттай шууд холбоотой болох нь харагдаж байна. Тухайлбал Хөвсгөл аймагт онц ноцтой хэрэг гарсантай холбоотойгоор хууль сахиулах байгууллагынхан бүрэн бүрэлдэхүүнээрээ төвлөрч ажилласнаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын шатнаас хэрэг шүүхэд шилжих явц удааширч шүүх хуралдааны тоо эрс багассан нөхцөл байдал үүссэн байна.

Ийм учраас шүүх хуралдааны тов, цагийг тогтоохдоо хэргийн оролцогч нар болон иргэдэд чирэгдэл учруулахгүйн тулд шүүгчдийн цаг /бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх хэргийн тухайд илүү хамаатай/, мөн прокурор, өмгөөлөгчдийн хуралдааны давхцал, ажлын боломж бололцоо болон шүүх хуралдааны танхимын зай, чөлөөг зөв харгалзан тогтоох шаардлагатай.

Шүүх хуралдааныг товлосон цагт эхлүүлэх асуудлаар Цагдан хорих 461 дүгээр ангийн захиргаатай зөвшилцөж, шийдэлд хүрэх хэрэгтэй байна. Үүний зэрэгцээ шүүхийн мэдээлэл лавлагааны ажилтан шүүхийн мэдээллийн самбарыг ажиллуулах, шүүх хуралдааны товыг тогтмол зарлаж байх нь шүүх хуралдааныг товлосон цагтаа эхлүүлэх, давхцал үүсгэхгүй байх нөхцлийг бүрдүүлэхэд чухал болохыг анхаарах нь зүйтэй.


2.3.3. Шүүх хуралдаан хойшилсон эсэх, хойшилсон шалтгаан

► Хуулийн үндэслэл


ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛИЙН 52 дугаар зүйлийн 52.4-т зааснаар хэргийг дангаар шийдвэрлэж байгаа шүүгчийг хуульд заасан үндэслэлээр татгалзвал шүүгч шүүх хуралдааныг хойшлуулж, уг асуудлыг тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид танилцуулж шийдвэрлүүлэх ба мөн хуулийн 242 дугаар зүйлийн 242.1-д заасны дагуу прокурор, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцох боломжгүй бол энэ тухай урьдчилж бичгээр шүүхэд заавал мэдэгдэх бөгөөд шүүх хуралдаанд прокурор, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч ирээгүй бол, мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 419 дүгээр зүйлийн 419.1-д зааснаар шүүх хуралдаанд хохирогч, шүүгдэгч, прокурор, өмгөөлөгч ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болно.

► Ажиглалтын дүн


Доорх графикт ажиглалтад хамрагдсан шүүх хуралдаан хойшлогдсон эсэх болон түүний шалтгааныг харуулахыг зорилоо.




Баянзүрх дүүргийн шүүх




Сүхбаатар дүүргийн шүүх




Сонгино хайрхан дүүргийн шүүх




Хан-Уул дүүргийн шүүх





Чингэлтэй дүүргийн шүүх



Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх





Ажиглалтын 269 хүчинтэй хуудасны 76-д буюу 28,3 хувьд шүүх хуралдаан ямар нэг шалтгаанаар хойшилсон бөгөөд нийт хуралдааны 21.6 хувь нь өмнө нь ямар нэг шалтгаанаар хойшилж байсан гэх дүн гарсан нь анхаарууштай асуудал юм.

Өөр нэг анхаарал татсан асуудал бол шүүх хуралдаан хойшилсон нь үнэн хэрэгтээ шүүгчээс шалтгаалдаггүй (5.6 хувь) бөгөөд өмгөөлөгч (44,4 хувь) болон бусад оролцогчоос (30,6 хувь) дийлэнхи тохиолдолд хамаарч буй явдал.

Түүнчлэн шүүгч хуралдаан товлосон цагт байхгүй буюу цайндаа гараад ирж амжаагүй гэх шалтгааны улмаас хойшлох тохиолдол ажиглалтын явцад гарчээ⁸. Хуульчдад зориулсан нэгдсэн сургалт болсноос шалтгаалан шүүх хуралдаан бас хойшилж байжээ.

Шүүх хуралдаан хойшилж буй үндэслэл, шалтгаанд дүгнэлт хийж, бодит нөхцөл байдлыг судлан тогтоох, цаашид шүүх хуралдааныг товлосон хугацаанд явуулахад Улсын Ерөнхий Прокурорын Газар болон Монголын Өмгөөлөгчдийн Холбооноос анхаарах цаг болжээ. Шүүх хуралдаанаас хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хоцорсон, хойшлуулсан тохиолдол бүрийг судлан, холбогдох арга хэмжээг авах хэрэгтэй юм.

⁸ Сүхбаатар дүүргийн шүүхэд энэ тохиолдол гарсаныг ажиглагч тэмдэглэсэн байна.

Шүүхийн зүгээс шүүх хуралдааныг оролцогчдын цаг боломжтой уялдуулахыг аль болох эрмэлзэхийн зэрэгцээ шүүх бүрэлдэхүүний ажлын давхцал, хуралдаан хоорондын зай гэх мэт үзүүлэлтийг харгалзан товлож, товлосон цагийг баримтлах, зохион байгуулалт, бэлтгэлийг хангах байх талаар холбогдох хүмүүс анхаарах нь зүйтэй юм.

2.3.4. Шүүхэд хэв журам, аюулгүй байдлыг хангаж буй байдал


Шүүх хуралдаан даргалагч хуралдааны дэгийг танилцуулж, уг дэгийг сахих үүрэгтэйг сануулсан байдал

► Хуулийн үндэслэл

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛИЙН 237⁹, 260 дугаар зүйлд¹⁰ зааснаар шүүх хуралдаан даргалагч нь шүүх хуралдааны дэгийг сахихыг оролцогчдод тайлбарлах, мөн хуулийн 251 дүгээр зүйлийн 251.4 дэх хэсэгт¹¹ зааснаар шүүх хуралдааны дэг сахих талаар хуралдаан даргалагч шийдвэр гаргах, оролцогчид түүнд захирагдах үүрэгтэй байна.

► Ажиглалтын дүн

Шүүх хуралдааны даргалагч оролцогчдод дэгийг сануулсан эсэх гэсэн асуултад хариулсан байдлыг доорх графикаас харна уу (Тийм гэсэн хариулт, хувиар).



⁹ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 237 дугаар зүйл. Шүүх хуралдаан даргалагч. 237.3. Шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдааны дэгийг сахиулах арга хэмжээ авч оролцогчид эрх, үүргийг нь тайлбарлан өгнө.

¹⁰ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 260 дугаар зүйл. Шүүх хуралдаанд оролцогчид түүний эрх, үүргийг тайлбарлах. 260.1. Шүүх хуралдаан даргалагч нь шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч, шинжээч нарт энэ хуулийн 36, 42-44, 46-д заасан эрх, үүргийг тайлбарлаж өгнө.

¹¹ 251.4. Шүүх хуралдаанд оролцогч болон шүүх хуралдааны танхимд байгаа бусад иргэд шүүх хуралдааны дэг сахих талаар хуралдаан даргалагчаас гаргасан шийдвэрт захирагдана.

Шүүгч шүүх хуралдаанд оролцогчдод эрх, үүргийг нь харьцангуй сайн сануулж байгаа ч оролцогчид түүнийг бүрэн ойлгосон эсэхээс хамаарч дэг зөрчигдөх тохиолдол түгээмэл гарч байна.

Шүүх хуралдааны дэг зөрчигдөж буй байдал

► Хуулийн үндэслэл

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛИЙН 237 дугаар зүйлийн 237.3-т зааснаар шүүх хуралдааны даргалагч нь шүүх хуралдааны дэгийг сахиулах арга хэмжээ авах үүрэгтэй бөгөөд шүүгдэгч шүүх хуралдааны дэгийг зөрчвөл хуралдааны танхимаас гаргах тухай урьдчилан сануулах ба дахин ийм зөрчил гаргавал шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар хуралдааны танхимаас гарган торгууль ногдуулах эрхтэй.

► Ажиглалтын дүн

№	Шүүхийн нэр	Шүүх хуралдааны дэг зөрчигдсөн эсэх талаар	
		Асуулгад хариулсан байдал	Тайлбар
1	Баянгол дүүргийн шүүх	35 асуулгын хуудасны 1-д буюу 2.9 хувьд дэг зөрчигдсөн	Шүүх хуралдааны явцад өмгөөлөгч, прокурорын гар утас дуугарах; иргэдийн төлөөлөгч шүүх хуралдааны дундуур юм идэх; өмгөөлөгч, прокурор нь үг хэлэхдээ суудлаасаа босохгүй байх; шүүх хуралдааны явцад тухайн шүүхийн өөр шүүгч танхимд орж гарах зэрэг зөрчил ажиглагдлаа.
2	Баянзүрх дүүргийн шүүх	31 асуулгын хуудасны 5-д буюу 16.1 хувьд дэг зөрчигдсөн	Шүүх хуралдааны явцад өмгөөлөгч шүүгдэгчийн гэр бүлийн хүнтэй ярих, шүүх хуралдаан эхэлсний дараа оролцогчид хоцорч орж ирэх зэргээр дэг зөрчигдөж байсан ч шүүгч ямар нэг арга хэмжээ аваагүй.
3	Сүхбаатар дүүргийн шүүх	44 асуулгын хуудасны 1-д буюу 2.3 хувьд дэг зөрчигдсөн	Шүүгчид шүүх хуралдааны дэгийг сахиулах асуудлыг анхаарсангүй.

№	Шүүхийн нэр	Шүүх хуралдааны дэг зөрчигдсөн эсэх талаар	
		Асуулгад хариулсан байдал	Тайлбар
4	Сонгинохайрхан дүүргийн шүүх	56 асуулгын хуудасны 26-д буюу 46.2 хувьд дэг зөрчигдсөн.	Шүүх хуралдааны дэг бүрэн гүйцэд сахигдсангүй.
5	Хан-Уул дүүргийн шүүх	29 асуулгын хуудасны 3-т буюу 10.3 хувьд дэг зөрчигдсөн	Шүүх хуралдааны танхимд оролцогчид дэг журамгүй байсан.
6	Чингэлтэй дүүргийн шүүх	31 асуулгын хуудасны 5-д буюу 16.1 хувьд дэг зөрчигдсөн	Хохирогч утсаар ярих, шүүх хуралдаанд согтуу оролцох, иргэдийн төлөөлөгч унтах зэргээр шүүх хуралдааны оролцогч нар шүүхийг үл хүндэлсэн байдал гаргаж байв.
7	Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх	100 хувь дэг зөрчигдөөгүй гэж хариулжээ.	Шүүх хуралдааны дэгийг сайн сахиулсан.
8	Дорнод аймаг дахь Сум дундын I шүүх	16 асуулгын хуудасны 2-т буюу 12.5 хувьд дэг зөрчигдсөн	Шүүх хуралдааны дэгийг сайн сахисан.
9	Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүх	23 асуулгын хуудасны 2-т буюу 8.7 хувьд дэг зөрчигдсөн	Шүүгч нэг тохиолдолд нь сануулж, нөгөөд нь дэг зөрчсөн этгээдийг хуралдааны танхимаас гаргасан ба дэгийг сайн сахиулж байв.

Ажиглалтаас үзэхэд шүүх хуралдааны дэгийг байнга биш хэдий ч зөрчдөг, зөрчил нь утсаар ярих, хоорондоо ярих, хуралдааны дундуур орж гарах, идэж уух гэх мэт хэлбэртэй байлаа. Зарим тохиолдолд хохирогч согтуугаар шүүх хуралдаанд оролцох зэргээр шүүх хуралдааны дэгийг ноцтой зөрчсөн ч шүүгч энэ байдалд ямар нэг арга хэмжээ аваагүй байна.

Шүүгчид хуралдааны дэгийг зөрчиж буй бага сага үйлдлийг анзааралгүй орхиж байгаагаас үүдэн шүүхийг үл хүндэтгэх байдлыг буй болгож байна.

Шүүх хуралдааны танхимд дэг сахиулах цагдаа үүргээ гүйцэтгэж буй байдал

► Хуулийн үндэслэл

ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 69 дүгээр зүйлийн 69.5-д зааснаар Шүүхийн тамгын газар, хэлтэс, алба нь шүүх хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангах, шүүхийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах ажлыг эрхлэн гүйцэтгэх ба шүүх хуралдааны дэг журмыг сахиулах, шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, шүүгдэгчийг хуяглан хүргэх, шүүхийн дуудлагаар ирэхгүй байгаа шүүгдэгч, гэрч, шүүхээс оргон зайлсан яллагдагч, шүүгдэгч, зохигчийг эрэн сурвалжлах үүргийг цагдаагийн байгууллага гүйцэтгэхээр заасан байна. Мөн хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-т шүүх хуралдааны аюулгүй байдлыг сахин хамгаалах үүрэгтэй цагдаагийн байгууллагын ажилтан болох шүүхийн цагдаагийн ажиллах журмыг Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтоохоор заасан. Энэ заалтын дагуу 2003 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 294 дүгээр хамтарсан захирамж, тушаалаар “Шүүхийн цагдаагийн ажиллах журам”-ыг баталжээ. Уг журмын дагуу шүүхийн цагдаа шүүх хуралдааны дэгийг сахиулах, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, шүүхийн дуудлагад ирэхгүй байгаа шүүгдэгч, гэрч, шинжээчийг албадан ирүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулсан.

Шүүхийн цагдаа¹² нь аймаг нийслэлийн цагдаагийн газар /хэлтэс/-ын бие бүрэлдэхүүнд багтаж, тухайн шүүхийн тамгын хэлтсийн даргын өдөр тутмын удирдлагад ажиллан Цагдаагийн байгууллагын тухай хуульд заасан эрх, үүргийн хүрээнд дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан яллагдагч, шүүгдэгчийг шүүх хуралдаанд хүргэж ирсэн хуяглан хүргэгчээс хүлээн авч, тусгай өрөөнд хяналтдаа байлган, шүүх хуралдаанд харгалзан оруулах;
- шүүх хуралдааны үед танхимд байж, хуралдааны аюулгүй байдлыг сахин хамгаалах;
- шүүх хуралдааны дэг зөрчсөн шүүгдэгч, зохигч, оролцогчийг шүүгчийн захирамжийн дагуу хуралдааны танхимаас гаргах, дуудсан үед оруулах;
- танхимд байгаа бусад хүн шүүх хуралдааны дэг зөрчсөн бол даргалагчийн шийдвэрээр танхимаас гаргах;

¹² Шүүхийн цагдаагийн ажиллах журмын 2.1-д зааснаар аймаг, нийслэлийн Цагдаагийн газар /хэлтэс/-ын дарга нь тухайн нутаг дэвсгэрийн шүүхэд ажиллах хуягийн тоог холбогдох шүүхийн тамгын хэлтсийн даргатай тохиролцож тогтоосны үндсэн дээр цагдаагийн албан хаагчийг шүүхийн цагдаагаар ажиллуулахаар нэг жилийн хугацаатай томилно.

- шүүх хуралдааны явцад болон завсарлагаанаар шүүгдэгчийг өмгөөлөгчөөс бусад хүнтэй уулзуулахгүй байх, бусдаас юм авахуулахгүй байх;
- шүүх хуралдаан дууссаны дараа шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр ялтныг хяналтдаа байлган гэр бүлийнхэнтэй нь уулзуулах;
- хорих ял шийтгэгдсэн ялтныг харгалзан хуяглан хүргэгчид хүлээлгэн өгөх.

Шүүхийн цагдаа нь шүүх хуралдаанд саад учруулсан буюу шүүх бүрэлдэхүүн, хуралдаанд оролцогчдын амь бие, эрүүл мэндэд нь хүч хэрэглэн халдсан үед өөр аргаар зогсоох боломжгүй бол бие хамгаалах тусгай хэрэгсэл, галт зэвсгийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэглэж¹³ болно.

► **Ажиглалтын дүн**

Шүүх хуралдааны дэгийг сахиулах чиг үүрэг бүхий цагдаа нь шүүх хуралдааны үед танхимд байж, хуралдааны аюулгүй байдлыг сахин хамгаалах үүргээ төдийлөн хариуцлагатай гүйцэтгэхгүй байгаа нь ажиглалтаар харагдлаа. Иймд шүүхийн цагдааг эрүүгийн хэрэг хянан хэлэлцэх шүүх хуралдаанд заавал оролцуулж хэвшүүлэх талаар шүүгч болон шүүхийн цагдаагийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан ажиллах чиг үүрэг бүхий шүүхийн тамгын хэлтэс, албад анхаарч, зохих арга хэмжээг авах нь зүйтэй байна. Мөн хэд хэдэн эрүүгийн хэрэг зэрэг шийдвэрлэгдэх буюу эрүүгийн шүүх хуралдаан зэрэг болох тохиолдолд шүүх хуралдааны дэгийг сахиулах цагдаа хэрхэн хүрэлцэж ажиллах нь ойлгомжгүй байгаа тул уг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай юм.

№	Шүүхийн нэр	Шүүх хуралдааны танхимд дэг сахиулах цагдаа байсан эсэх талаар	
		Асуулгад хариулсан байдал	Тайлбар
1	Баянгол дүүргийн шүүх	52 хувьд дэг сахиулах цагдаа байсан	Шүүхийн цагдаа хурлын дундуур орж гардаг, танхимд байнга байж хуралдааны аюулгүй байдлыг сахин хамгаалах үүргээ биелүүлэхгүй байна.
2	Баянзүрх дүүргийн шүүх	46.2 хувьд дэг сахиулах цагдаа байсан	Шүүхийн цагдаа хуралдааны дундуур орж гардаг. Шүүх хуралдаан дууссаны дараа нарийн бичгийн дарга цагдааг дуудсанаар шүүгдэгчийг авч гарах болон гэрчийг дуудаж оруулахад шүүхийн цагдаа байгаагүй, нарийн бичгийн дарга нь шүүхийн цагдаагийн үүргийг гүйцэтгэж байсан тохиолдол гарсан.
3	Сүхбаатар дүүргийн шүүх	77.3 хувьд дэг сахиулах цагдаа байсан	Шүүхийн хэв журам сахиулах цагдаа нь зөвхөн цагдан хоригдсон шүүгдэгч шүүх хуралдаанд оролцож байгаа тохиолдолд хуралдаанд оролцдог бөгөөд бусад үед оролцдоггүй. Шүүх хуралдааны танхимд дэг сахиулах цагдаа үүргээ сайн биелүүлдэг.
4	Сонгинохайрхан дүүргийн шүүх	32.1 хувьд дэг сахиулах цагдаа байсан	Шүүхийн цагдаа нь хангалттай сайн ажиллахгүй байна.

¹³ “Шүүхийн цагдаагийн ажиллах журам”-ын 6.3-т “Цагдаагийн байгууллага шүүхийн цагдаад галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгслийг албан хэрэгцээнд олгож, цагдаагийн алба хаагч галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх журмын дагуу ашиглалтад нь хяналт тавина” гэж заажээ.

№	Шүүхийн нэр	Шүүх хуралдааны танхимд дэг сахиулах цагдаа байсан эсэх талаар	
		Асуулгад хариулсан байдал	Тайлбар
5	Хан-Уул дүүргийн шүүх	83.3 хувьд дэг сахиулах цагдаа байсан	Шүүхийн цагдаа нь жижүүр болон цагдаагийн үүргийг давхар гүйцэтгэж байсан.
6	Чингэлтэй дүүргийн шүүх	69.6 хувьд дэг сахиулах цагдаа байсан	Шүүхийн цагдаа шүүх хуралдааны дундуур орж гардаг.
7	Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх	100 хувьд дэг сахиулах цагдаа байсан	Ажиглалтад хамрагдсан бүх шүүх хуралдаанд дэг сахиулах цагдаа байсан.
8	Дорнод аймаг дахь Сум дундын I шүүх	20 хувьд дэг сахиулах цагдаа байсан	Шүүхийн цагдаа хангалтгүй ажиллаж байна.
9	Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүх	100 хувьд дэг сахиулах цагдаа байсан байна.	Ажиглалтад хамрагдсан бүх шүүх хуралдаанд дэг сахиулах цагдаа байсан.

2.4. Шүүхийн байрны нөхцөл байдал

2.4.1. Шүүхийн байршил

► Хуулийн үндэслэл

ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэгт зааснаар шүүхийг байгуулахдаа түүний харьяалан ажиллах нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтрал, аж ахуйн нэгж, байгууллагын тоо, хэрэг, маргааны гаралтын түвшин, бүс нутаг, нутаг дэвсгэрийн ойр дөт байдлыг харгалзан үзэх ёстой.

Шүүхийн байр нь шүүхээр үйлчлүүлэхээр ирсэн иргэдийн хувьд хайж олоход хялбар, нийтийн тээврийн хэрэгслийн буудлын ойролцоо, хаяг нь нүдэнд ил харагдахаар байрласан байх нь чухал юм.

► Ажиглалтын дүн

Хөдөө, орон нутгийн шүүхүүд байршлын хувьд аймгийн төвд, нутгийн захиргааны байгууллагууд төвлөрсөн, хөл хөдөлгөөн ихтэй газар байрладаг, иргэд эрж олоход хялбар байрласан байна. Харин нийслэлийн төвийн дүүргийн шүүхүүдийн тухайд Сонгинохайрхан дүүргийн шүүхээс бусад нь байршил сайтай боловч шүүхийн байршил, хаягийн тэмдэг, тэмдэглэгээ хийж, иргэдэд шүүхийг эрж, хайлгүй, хялбар олоход дэмжлэг болох зүйл ажиглагдсангүй.

№	Шүүхийн нэр	Шүүхийн байрны байршлын тухай	
		Асуулгад хариулсан байдал ¹⁴	Тайлбар
1	Баянгол дүүргийн шүүх	32 асуулгын хуудасны 23-т нь буюу 71.9 хувь нь байршил сайтай	Дүүргийн төвд, нийтийн тээврийн зогсоол, үйлчилгээнд ойр байрладаг.
2	Баянзүрх дүүргийн шүүх	42 асуулгын хуудасны 41-д буюу 97.7 хувь нь байршил сайтай	Дүүргийн захиргааны байгууллага болон бусад шаардлагатай үйлчилгээ /банк, нотариат гэх мэт/-нээс зайдуу боловч олоход хялбар, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд ойр байрладаг.
3	Сүхбаатар дүүргийн шүүх	43 асуулгын хуудасны 41-д буюу 93.2 хувь нь байршил сайтай	Хотын төвд бусад захиргааны болон шүүхтэй харьцангуй ойр байрласан, шүүхийн байрны дэргэд “Нэг цонхны үйлчилгээ” буюу татвар, нийгмийн даатгал, бүртгэлийн байгууллага, банк, мөн нотариатын үйлчилгээ байгаа нь давуу талтай юм.

¹⁴ Хавсралт /Ажиглагчдын асуулгад хариулсан байдлыг зөвхөн хүчинтэй санал асуулгын хуудасны дүнгээр тооцон дүгнэсэн/-аас харна уу.

№	Шүүхийн нэр	Шүүхийн байрны байршлын тухай	
		Асуулганд хариулсан байдал	Тайлбар
4	Сонгинохайрхан дүүргийн шүүх	56 асуулгын хуудасны 45-д буюу 80.4 хувь нь байршил муутай	Төв зам, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолоос хол байрладаг бөгөөд шүүхийн байр хүрэх зам нь хойноосоо ороход хялбар бол урдаасаа буюу төв зам талаасаа ороход түвэгтэй. Иргэдийн орон сууцны дунд нуугдмал байдалтай нь хайж олоход хүндрэлтэй.
5	Хан-Уул дүүргийн шүүх	29 асуулгын хуудасны 21-д буюу 74.2 хувь нь байршил муутай	Шүүхийн байр нь дүүргийн Цагдаагийн газрын дэргэд, Засаг даргын Тамгын газрынхаа ойролцоо, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолоос холгүй байрладаг боловч хаяг нь нүдэнд ил биш, эрж олоход хялбар биш.
6	Чингэлтэй дүүргийн шүүх	29 асуулгын хуудасны 19-д буюу 61.3 хувь нь байршил сайтай	Хотын төвд байрладаг боловч хаяг нь нүдэнд ил биш, эрж олоход хялбар биш.
7	Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх	14 асуулгын хуудсанд 100 хувь байршил сайтай	Аймгийн төвд, нутгийн захиргааны байгууллагын ойролцоо байрладаг.
8	Дорнод аймаг дахь Сум дундын I шүүх	16 асуулгын хуудсанд 100 хувь байршил сайтай	Аймгийн төвд, нутгийн захиргааны байгууллагууд төвлөрсөн газар байрладаг.
9	Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүх	22 асуулгын хуудсанд 100 хувь байршил сайтай гэж хариулжээ.	Аймгийн төв дотроо, олон нийтийн хөл хөдөлгөөн ихтэй газар оршдог.

Ажиглалтаар байршил муутай, иргэдийн хувьд хайж олоход түвэгтэй гэж дүгнэгдсэн шүүхүүд нь өөрийн байрны ойролцоо, харьяалах нутаг дэвсгэрийн төрийн захиргаа болон цагдаа, прокурор, өмгөөллийн байгууллагуудад шүүхийн байршил заасан тэмдэг, тэмдэглэгээ, зурагт хуудас байрлуулах шаардлагатай.

Түүнчлэн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн байрны байршлыг зам дагуу, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын ойролцоо байхаар шилжүүлэн байршуулах арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзлээ.

2.4.2. Шүүх иргэдэд шаардлагатай мэдээллийг зохих хэлбэрээр хүргэж буй байдал

► Хуулийн үндэслэл

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН 54 дүгээр зүйл, Шүүхийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 235 дугаар зүйлд “Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүх хуралдааныг нээлттэй явуулах” тухай заасан төдийгүй шүүхийн мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс 2007 оны 10 дугаар сарын 19-ний өдөр 68 дугаар тогтоол гаргаж, “Шүүхийн мэдээлэл, лавлагааны албаны ажиллах журам”-ыг баталсан байна. Уг журамд шүүхийн мэдээлэл, лавлагааны албаны үйл ажиллагаа “Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй байлгах, шүүхэд хандаж буй иргэн, хуулийн этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх ...”-д чиглэгдэхээр зааж, улмаар шүүхийн мэдээлэл, лавлагааны албаны бүтэц, гүйцэтгэх ажлын чиглэлийг тодорхойлжээ. Мөн тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Аймаг, нийслэлийн захиргааны хэргийн болон сум, сум дунд, дүүргийн шүүхийн мэдээлэл, лавлагаа хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолт”-ын б-д: “Шүүхийн мэдээллийн самбарыг хариуцан ажиллуулах, нэхэмжлэл бичих загвар, нэхэмжлэлийн бүрдүүлбэр, тэмдэгтийн хураамжийн хуулийн холбогдох заалт, торгууль, хураамж төлөх дансны дугаар, шүүхийн удирдлагаас иргэдийг хүлээн авч уулзах хуваарь, шүүх хуралдааны тов зэргийг “Шүүхийн мэдээллийн самбар”-т заавал байрлуулах”-аар заажээ.

► Ажиглалтын дүн

Шүүх шаардлагатай мэдээллийг ил тавьдаг эсэх талаар			
№	Шүүхийн нэр	Асуулгад хариулсан байдал ¹⁵	Анхаарал татсан асуудал
1	Баянгол дүүргийн шүүх	32 асуулгын хуудасны 28-д буюу 93.3 хувьд нь шаардлагатай мэдээлэл ил	Зарлагдсан зарим шүүх хуралдаан ямар үндэслэл, хугацаагаар хойшилсныг урьдчилан мэдэх /товлосон хугацаанаас өмнө шүүх хуралдаанд оролцогчид шүүх хурлыг хойшлуулах хүсэлтийг урьдчилан гаргасан тохиолдолд/ боломж байдаггүй бөгөөд шүүгч, шүүхийн нарийн бичгийн дарга нараас л лавлаж мэдэх боломжтой.
2	Баянзүрх дүүргийн шүүх	44 асуулгын хуудасны 43-т буюу 97.6 хувь нь шаардлагатай мэдээлэл ил	Өглөө 9.00 цагт эхлэх шүүх хуралдаанд 8.30 цагт очиж, 10.00 цаг хүртэл хүлээсэн боловч шүүх хуралдааны талаар ямар нэг мэдээлэл өгөөгүй ба шүүхийн жижүүрээс асуухад “хохирогч байхгүй тул шүүх хуралдаан хойшилсон” гэв. Энэ талаар шүүгчийн туслахаас тодруулах гэсэн боловч шүүх хуралд орсон байснаас мэдээлэл авч чадаагүй.

¹⁵ Хавсралт /Ажиглагчдын асуулгад хариулсан байдлыг зөвхөн хүчинтэй санал асуулгын хуудасны дүнгээр тооцон дүгнэсэн/-аас харна уу.

Шүүх шаардлагатай мэдээллийг ил тавьдаг эсэх талаар			
№	Шүүхийн нэр	Асуулганд хариулсан байдал	Анхаарал татсан асуудал
3	Сүхбаатар дүүргийн шүүх	44 асуулгын хуудасны 43-г буюу 97.6 хувь нь шаардлагатай мэдээлэл ил	Иргэдэд шаардлагатай мэдээлэл болох шүүх хурлын тов болон бусад мэдээллийг мэдээллийн самбарт байрлуулснаас гадна мэдээллийн нэг ажилтан байнга ажилладаг.
4	Сонгинохайрхан дүүргийн шүүх	56 асуулгын хуудасны 53-г буюу 94.3 хувь нь шаардлагатай мэдээлэл ил	Иргэдэд шаардлагатай мэдээлэл болох шүүх хурлын тов болон бусад мэдээллийг мэдээллийн самбарт байрлуулснаас гадна мэдээллийн нэг ажилтан байнга ажилладаг.
5	Хан-Уул дүүргийн шүүх	29 асуулгын хуудасны 26-д буюу 89.6 хувь нь шаардлагатай мэдээлэл ил	Шүүх хуралдаан хойшилсон талаар хэргийн оролцогч нарт утсаар болон бусад хэлбэрээр мэдэгддэг боловч тухайн хуралдааныг сонирхсон иргэдэд уг мэдээлэл нээлттэй биш байна.
6	Чингэлтэй дүүргийн шүүх	29 асуулгын хуудасны 23-г буюу 79.3 хувь нь шаардлагатай мэдээлэл ил	Зарлагдсан шүүх хуралдаан хойшилсон тухай мэдээллийн самбарт мэдээлэл тавьдаггүй. Мэдээллийн самбарт тавьсан шүүх хуралдааны зар дээр сум зааж тэмдэглэсэн нь ойлгомжгүйн дээр тухайн хуралдаан болох эсэх, нэгэнт зарлагдсан хуралдаан яагаад өөрчлөгдсөн нь тодорхойгүй байв. Тухайн 7 хоногтоо хуралдааныг 1-2 өдрөөр хойшлуулж, урагшлуулах нь ажиглагдсан.
7	Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх	14 асуулгын хуудасны 5-д буюу 35.7 хувь нь шаардлагатай мэдээлэл ил	Шүүх хуралдааны товыг тавиагүй /2010 оны 4 дүгээр сарын 13-ны өдрөөс мөн сарын 30-ны хооронд 4-5 удаагийн давтамжтай/, таньдаг хүнээсээ утсаар сураглаж байж хуралдааны товыг мэдсэн. Шүүх хуралдааны товын дагуу очтол тухайн шүүх хуралдаан хаалттай явагдсан ба шүүх хуралдааныг нээлттэй, хаалттай явуулах тухай мэдээлээгүй.
8	Дорнод аймаг дахь Сум дундын I шүүх	100 хувь шаардлагатай мэдээлэл ил	Шүүх иргэдэд шаардлагатай мэдээллийг мэдээллийн самбарт тогтмол тавьдаг.
9	Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүх	23 асуулгын хуудасны 22-г буюу 95.7 хувь нь шаардлагатай мэдээлэл ил	Шүүх иргэдэд шаардлагатай мэдээллийг нээлттэй хүргэдэг.

Нийт ажиглалтын 31.9 хувьд нь шүүх шаардлагатай мэдээллийг зохих хэлбэрээр иргэдэд хүргэхгүй байгаа ба хөдөө орон нутгийн буюу сум дундын шүүхүүд иргэдэд мэдээллийг ил тод хүргэхгүй байна. Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүхийн тухайд ажиглагчдын 64.3 хувь нь шаардлагатай мэдээллийг ил гаргаж тавиагүй гэж дүгнэсэн байна.

Мөн шүүх хуралдааны зарыг зохих хугацаанд мэдээллийн самбарт тавьдаггүй, шүүх хуралдаан зарлагдсан хугацаанаас нааш, цааш өөрчлөгддөг, шүүх хуралдаанд оролцогчдын хүсэлтээр шүүх хуралдааны тов өөрчлөгдсөн талаарх мэдээлэл тухайн шүүх хуралдааныг сонирхогчдод ил тод биш, мэдээллийг ойлгомжгүй тэмдэг, тэмдэглэгээгээр өгдөг, шүүх хуралдааныг хаалттай, эсвэл нээлттэй явуулах талаар мэдээлдэггүй байдал нийт шүүхүүдийн хэмжээнд ажиглагдлаа.

Шүүх хуралдааны талаарх мэдээллийг улам бүр ил тод, тодорхой ойлгомжтой болгох нь зүйтэй. Үүний тулд шүүх хуралдааныг нээлттэй, хаалттай явуулах эсэх талаарх мэдээлэл, мөн шүүх хуралдаан хойшилсон тохиолдолд ямар үндэслэлээр болон ямар хугацаагаар хойшилсон тухай шуурхай мэдээлж байх хэрэгтэй байна.

Шүүх бүр мэдээллийн самбар дахь мэдээллээ орчин үеийн техник хэрэгсэл ашиглан, тухайлбал, өөрийн цахим хаягт байрлуулах гэх мэтээр аль болох иргэдэд хялбар байдлаар ил тод байлгах нь зүйтэй.

2.4.3. Шүүхийн байр, шүүх хуралдааны танхимын зай хэмжээ, багтаамж, хүртээмжтэй байдал

Шүүхийн байрны тухайд

► *Хуулийн үндэслэл*

ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 86 дугаар зүйлийн 86.1-д “Төрийн захиргааны болон бусад байгууллага шүүхийг байнга болон нүүдлэн ажиллах байр, шаардлагатай тоног төхөөрөмж, тээврийн болон техник хэрэгсэл, шүүгчийг орон байраар хангах зэрэг шүүх, шүүч үйл ажиллагаагаа хараат бусаар явуулах нөхцлийг бүрдүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлнэ” гэж заасан байдаг ба Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс шүүхийн байгууллагын үндсэн зорилт, чиг үүргээ хэрэгжүүлж хэвийн тогтвортой ажиллах нөхцөл, бололцоог бүрдүүлэх, шүүхээр үйлчлүүлж байгаа иргэн, байгууллагад үйлчлэхэд чиглэсэн үйл ажиллагааны стандартыг боловсруулж гаргасан байдаг.

► *Ажиглалтын дүн*

Шүүхийн байр /гадаад талбай мөн хамаарна/, шүүх хуралдааны танхим нь зай багтаамж сайтай, ариун цэвэр, эрүүл ахуйн стандарт шаардлагыг хангасан байх нь шүүхийн дотоод зохион байгуулалтыг эмх цэгцтэй болгохоос гадна шүүхэд хандсан, шүүн таслах үйл ажиллагааг ажиглахаар ирсэн иргэдэд эерэг уур амьсгал бүрдүүлж, тэдний эрхээ хэрэгжүүлэх боломжийг олгож байгаа хэрэг болно.

№	Шүүхийн нэр	Шүүхийн байр хангалттай зайтай эсэх талаар	
		Асуулгад хариулсан байдал ¹⁶	Тайлбар
1	Баянгол дүүргийн шүүх	32 асуулгын хуудасны 10-г буюу 28.6 хувьд хангалтгүй	Зай багтаамж дунд зэрэг. Шүүх хуралдааны танхимын гадна шуугиан ихтэй, шүүх хуралдааны оролцогч нарын яриа зарим тохиолдолд сонсогддоггүй.
2	Баянзүрх дүүргийн шүүх	42 асуулгын хуудасны 8-д буюу 18.6 хувьд хангалтгүй	Зай багтаамж дунд зэрэг.
3	Сүхбаатар дүүргийн шүүх	44 асуулгын хуудасны 36-д буюу 81.8 хувьд хангалтгүй	Зай багтаамж муу.
4	Сонгинохайрхан дүүргийн шүүх	56 асуулгын хуудасны 43-г буюу 76.8 хувьд хангалтгүй	Зай багтаамж муу.
5	Хан-Уул дүүргийн шүүх	29 асуулгын хуудасны 12-г буюу 41.4 хувьд хангалтгүй.	Зай багтаамж дунд зэрэг. Хэргийн оролцогч болон шүүх хуралдаан сонирхсон иргэд олон байх тохиолдолд зай багтаамж хүрэлцээгүй болдог. Шүүхийн байр засвартай байсны улмаас шүүх хуралдааны танхимын гадна шуугиан ихтэй байв.
6	Чингэлтэй дүүргийн шүүх	29 асуулгын хуудсанд 100 хувьд хангалтгүй	Зай багтаамж маш муу. Шүүх хуралдааны танхимын гадна шуугиан ихтэй, шүүх хуралдааны оролцогч нарын яриа зарим тохиолдолд сонсогддоггүй /прокурорын яриа сонсогдохгүй хохирогчийн өмгөөлөгч шүүгчээс зөвшөөрөл авч прокурорын хажууд суусан/.
7	Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх	14 асуулгын хуудасны 9-д буюу 64.3 хувьд хангалттай.	Зай багтаамж дунд зэрэг
8	Дорнод аймаг дахь Сум дундын I шүүх	10 асуулгын хуудасны 9-д буюу 90 хувьд хангалттай	Зай багтаамж сайтай.
9	Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүх	22 асуулгын хуудасны 21-д буюу 95.5 хувьд хангалттай зайтай гэж хариулсан байна.	Зай багтаамж сайтай.

¹⁶ Хавсралт /Ажиглагчдын асуулгад хариулсан байдлыг зөвхөн хүчинтэй санал асуулгын хуудасны дүнгээр тооцон дүгнэсэн/-аас харна уу.

Шүүхийн байрны зай багтаамжийн хувьд нийслэлийн болон аймгийн шүүхүүд бас харьцангуй өөр өөр дүр зурагтай байна. Хүн амын нягтаршил, гэмт хэргийн гаралт зэрэг хүчин зүйлээс шалтгаалаад хөдөө орон нутагт шүүхийн байрны зай багтаамж хангалттай байдаг бол хотын төвийн дүүргүүдийн хувьд тийм дүр зураг харагдахгүй байна.

Тухайн хэргийн онцлог оролцогчдын тоо зэргээс шалтгаалаад багтаамжийн асуудал харьцангуй тул нэгдсэн дүгнэлт хийх боломжгүй юм.

Шүүхийн байрны нөхцөл байдлын хувьд хотын дүүргийн шүүхүүдийн байрны асуудлыг дахин шийдэх цаг нэгэнт болжээ. Байршлын хувьд боломжийн гэж үзсэн шүүхүүдийн хувьд байрыг шинээр засварлан өргөтгөх, байршил муутай шүүхийн хувьд зохистой байршлыг тодорхойлон шинээр зай багтаамж сайтай байртай болгох шаардлагатай. Чингэлтэй дүүргийн хувьд энэ асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэх хэрэгтэй байна.

Шүүх хуралдааны танхимын тухайд

► Хуулийн үндэслэл

ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 26 дугаар зүйлд 26.1, 26.2-т “шүүх хуралдааныг шүүн таслах ажил явуулах шаардлага хангасан танхимд явуулах”, “шүүх хуралдааны танхимын загварыг Ерөнхий зөвлөл батлах”-аар заасны дагуу Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2006 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 16 дугаар тогтоол батлагдсан байна. Уг тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Шүүх хуралдааны танхимын ерөнхий шаардлага”-ын 1-д “Шүүх хуралдааны танхим нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан шүүх хуралдаанд оролцогчдын эрх, үүргийг хэрэгжүүлэх зохистой орчныг бүрдүүлсэн байхаас гадна шүүх хуралдааны танхимыг хуралдаанд оролцогчид олон нийтийн дунд ил тод харилцаа, ажил хэргийн тааламжтай нөхцлийг бүрдүүлэх зорилгоор мэтгэлцээний ба хөндлөнгийн ажиглагчдын гэсэн 2 хэсэгт хуваасан байх шаардлагатай.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 282 дугаар зүйлийн 282.1-ийн ”Шүүгдэгчийн эцсийн үгийг сонссоны дараа шүүх тогтоол гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орох ба шүүх хуралдаан даргалагч энэ тухай зарлан мэдэгдэнэ”, мөн хуулийн 285 дугаар зүйлийн 285.1-ийн ”Шүүх тогтоолыг зөвлөлдөх тасалгаанд үйлдэнэ”, 285.2-ын “Шүүгчид зөвлөлдөж байгаа үед зөвлөлдөх тасалгаанд уг хэргийг хэлэлцсэн шүүх бүрэлдэхүүнээс өөр хүмүүс байж болохгүй” гэх заалт, мөн “Анхан шатны шүүхийн эрүүгийн хэргийн шүүх хуралдааны танхимын загвар”-т тавигдсан шаардлагын дагуу анхан шатны шүүхийн эрүүгийн шүүх хуралдааны танхим нь заавал зөвлөлдөх тасалгаатай байх ёстой.

► **Ажиглалтын дүн**

Шүүх хуралдааныг нээлттэй явуулах зарчмыг хэрэгжүүлэх нэг нөхцөл бол шүүх хуралдааны танхимд хөндлөнгийн ажиглагчдын орон зайг хангалттай бий болгох явдал юм. Гэвч нийслэлийн төвийн дүүргийн шүүхүүдэд оролцогч олонтой хэргийг шийдвэрлэх үед танхим зайгүй, дүүрсэн гэх шалтгаанаар шүүн таслах үйл ажиллагааг ажиглах боломжгүйд хүрдэг. Өөрөөр хэлбэл, шүүх хуралдааны танхимын зай, багтаамжаас хамааран шүүх хуралдаанд оролцохыг хүсэгчид орж ажиглах боломжгүй байна.

№	Шүүхийн нэр	Шүүх хуралдааны танхим хангалттай зайтай эсэх талаар	
		Асуулгад хариулсан байдал ¹⁷	Тайлбар
1	Баянгол дүүргийн шүүх	32 асуулгын хуудасны 25-д буюу 78.1 хувьд хангалттай	Зай багтаамж дунд зэрэг. Шүүх хуралдааны танхим зөвлөлдөх тасалгаагүй бөгөөд шүүгч шийдвэр гаргахдаа бүх оролцогчдыг гарган шүүх хуралдааны танхимд үлдэн шийдвэрээ гаргадаг.
2	Баянзүрх дүүргийн шүүх	42 асуулгын хуудасны 34-т буюу 80.9 хувьд хангалттай	Зай багтаамж дунд зэрэг. Шүүх хуралдааны оролцогчдын яриа сонсогддоггүй, микрофон нь ажилладаггүй. Мөн эрүүгийн шүүх хуралдаан нь эрүүгийн танхимдаа бус иргэний танхимд явагдах тохиолдол байдаг. Шүүх хуралдааны танхим зөвлөлдөх тасалгаагүй.
3	Сүхбаатар дүүргийн шүүх	43 асуулгын хуудасны 38-д буюу 86.4 хувьд хангалттай	Зай багтаамж дунд зэрэг. Шүүх хуралдааны танхим зөвлөлдөх тасалгаагүй.
4	Сонгинохайрхан дүүргийн шүүх	56 асуулгын хуудасны 36-д буюу 64.3 хувьд хангалттай	Зай багтаамж дунд зэрэг. Шүүх хуралдааны танхимд байрлуулсан сандал хоорондын зай маш бага байсан нь сууж буй хүмүүст хэцүү байсан. Шүүх хуралдааны танхим зөвлөлдөх тасалгаагүй.
5	Хан-Уул дүүргийн шүүх	29 асуулгын хуудасны 25-д буюу 86.2 хувьд хангалттай	Зай багтаамж дунд зэрэг. Шүүх хуралдааны танхим зөвлөлдөх тасалгаагүй.
6	Чингэлтэй дүүргийн шүүх	29 асуулгын хуудасны 18-д буюу 62.1 хувьд хангалттай.	Зай багтаамж дунд зэрэг. Хэргийн оролцогч болон хурлыг сонирхсон иргэд олон байх тохиолдолд хүрэлцээгүй болдог. Шүүх хуралдааны танхим зөвлөлдөх тасалгаагүй.
7	Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх	14 асуулгын хуудасны 12-т буюу 85.7 хувьд хангалттай	Зай багтаамж сайтай.

¹⁷ Хавсралт /Ажиглагчдын асуулгад хариулсан байдлыг зөвхөн хүчинтэй санал асуулгын хуудасны дүнгээр тооцон дүгнэсэн/-аас харна уу.

Шүүх хуралдааны танхим хангалттай зайтай эсэх талаар			
№	Шүүхийн нэр	Асуулгад хариулсан байдал ¹⁷	Тайлбар
8	Дорнод аймаг дахь Сум дундын I шүүх	10 асуулгын хуудсанд 100 хувь хангалттай зайтай гэж	Зай багтаамж сайтай.
9	Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүх	23 асуулгын хуудасны 21-д буюу 91.3 хувьд хангалттай зайтай гэж хариулсан байна	Зай багтаамж сайтай.

Мөн нийслэлийн дүүргийн шүүхүүдийн тухайд эрүүгийн хэрэг хянан хэлэлцэх хуралдааны нэг танхимтай бөгөөд үүнээс шалтгаалан зарим тохиолдолд шүүх хуралдаан хойшилдог байна. Ихэнхи шүүхийн хуралдааны танхим зөвлөлдөх тасалгаагүй байгаа нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалтад нийцэхгүй байна.

Мөн тухайн шүүхийн дотоод ажлын зохион байгуулалттай холбоотойгоор шүүх хуралдааны танхимд гадны буюу шүүхийн үүдний танхимын дуу чимээ нэвтэрдгээс оролцогчдын дуу сонсогдохгүй байх тохиолдол нэлээд гардаг байна.

Нийслэлийн дүүргүүдийн шүүхэд олон оролцогч, сонирхогчтой, нээлттэй шүүх хуралдаан явуулах хангалттай зай багтаамжтай шүүх хуралдааны нэг танхимыг бий болгох, шүүгчийн наад захын хэрэглээний хууль тогтоомж, ном, гарын авлага, шаардлагатай техник хэрэгсэл бүхий зөвлөлдөх тасалгаа байгуулах шаардлагатай. Улмаар шүүх хуралдааны танхимын дуу чимээ тусгаарлалтыг сайжруулж, танхимын микрофоны байнгын ажиллагааг хангахад цаашид анхаарах хэрэгтэй.

Хүлээх танхимын тухайд

► Хуулийн үндэслэл

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН 48 дугаар зүйлийн 48.3-т “...Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана”, Шүүхийн тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.1-д “Төрийн захиргааны болон бусад байгууллага ... шүүх, шүүгч үйл ажиллагаагаа хараат бусаар явуулах нөхцлийг бүрдүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлнэ” гэж заасан.

Шүүхийн байгууллагын үндсэн зорилт, чиг үүргээ хэрэгжүүлж хэвийн тогтвортой ажиллах нөхцөл, бололцоог бүрдүүлэх, шүүхээр үйлчлүүлж байгаа иргэн, байгууллагад үйлчлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагааг өөрөөр хэлбэл, албан контор, ширээ, сандлаас эхлээд шаардлагатай бусад техник хэрэгслээр хангах, гэрэл дулаан, усны хангамж, цэвэрлэгээ, засвар, тохижилт, телефон утас, мэдээллийн технологийн хэрэгслээр үйлчлэх зэрэг санхүү, аж ахуйн бүхий л үйлчилгээ /арын алба/-г санхүү хангамжийн хүрээнд бий болгох ёстой¹⁸.

¹⁸ Шүүхийн менежментийн үндсэн асуудлууд. Шүүхийн ерөнхий зөвлөл, УБ., 2008, 153 дахь тал

► **Ажиглалтын дүн**

Нийслэлийн төвийн дүүргийн шүүхүүдэд оролцогч олонтой хэргийг шийдвэрлэх үед болон үдийн өмнө хүлээлгийн танхим хүрэлцээ муутай байх нь түгээмэл байна. Олон нийтэд зориулсан өрөө танхимын нөхцөл байдал ерөнхийдөө хангалтгүй байна. Тухайлбал, гэрч, хохирогч нарыг тусгайлан хүлээлгэх өрөө танхим байхгүй. Иргэдэд зориулсан сандал суудал нь хүрэлцэхгүй байна. Ялангуяа, шүүх хуралдаан товлосон цагтаа эхлэхгүй тохиолдолд гэрч, хохирогч, тэдний ар гэрийнхэн шүүгдэгчийн ар гэрийнхэнтэй нэг дор буюу нэг танхимд хүлээх нь тэдэнд таагүй байдаг бөгөөд энэ нь гэрч, хохирогч нар шүүх хуралдаанд ирэхгүй зайлсхийх нэг үндэслэл болдог. Олон улсын стандартаар гэрч, хохирогч, шүүгдэгч нарт тусгайлсан өрөө, тэр ч бүү хэл тэднийг өөр хаалгаар оруулж, гаргаж байхаар заасан байдаг. Үүний зэрэгцээ шүүхүүд ариун цэврийн өрөөг түгжээтэй байлгах, улмаар иргэдэд төлбөртэй үйлчилж буй нь зохимжгүй юм.

№	Шүүхийн нэр	Шүүхийн хүлээх танхим дахь хүлээлгийн сандал хангалттай эсэх талаар	
		Асуулгад хариулсан байдал ¹⁹	Тайлбар
1	Баянгол дүүргийн шүүх	32 асуулгын хуудасны 7-д буюу 21.9 хувьд хангалттай	Хүлээлгийн сандал хүрэлцээгүй, ариун цэврийн өрөө байнга түгжээтэй, төлбөртэй ашиглуулдаг нь иргэдэд хүндрэлтэй байна.
2	Баянзүрх дүүргийн шүүх	42 асуулгын хуудасны 6-д буюу 14.3 хувьд хангалттай	Хүлээх танхимд хангалттай тооны сандал байхгүй байна. Хэргийн оролцогч болон шүүх хуралдааныг сонирхсон иргэд олон байх тохиолдолд хүлээх танхимын зай багтаамж хүрэлцээгүй болдог.
3	Сүхбаатар дүүргийн шүүх	44 асуулгын хуудасны 38-д буюу 93.1 хувьд хангалттай	Хүлээх танхим нь өглөө ачаалал ихтэй үед зайгүй, суудлын тоо хүрэлцэхгүй, иргэд багтахгүй байх тохиолдол их байсан. Харин өдөр ачаалал багассан үед хүлээх танхимын сандлын хүрэлцээ харьцангуй боломжийн байсан.
4	Сонгинохайрхан дүүргийн шүүх	56 асуулгын хуудасны 33-т буюу 58.9 хувьд хангалттай	Хүлээлгийн танхим зай багтаамж багатай байна.
5	Хан-Уул дүүргийн шүүх	29 асуулгын хуудасны 21-д буюу 72.4 хувьд хангалттай	Хүлээх танхимд хангалттай тооны сандал байхгүй байна. Хэргийн оролцогч болон хурлыг сонирхсон иргэд олон байх тохиолдолд хүлээх танхимын зай багтаамж хүрэлцээгүй болдог.
6	Чингэлтэй дүүргийн шүүх	29 асуулгын хуудасны 9-д буюу 31 хувьд хангалттай	Хүлээлгийн сандал хүрэлцээгүй, хүлээлгийн өрөө хүйтэн, тохьгүй, ариун цэврийн өрөө байнга түгжээтэй байдаг нь иргэдэд хүндрэлтэй.

¹⁹ Хавсралт /Ажиглагчдын асуулгад хариулсан байдлыг зөвхөн хүчинтэй санал асуулгын хуудасны дүнгээр тооцон дүгнэсэн/-аас харна уу.

№	Шүүхийн нэр	Шүүхийн хүлээх танхим дахь хүлээлгийн сандал хангалттай эсэх талаар	
		Асуулгад хариулсан байдал ²²	Тайлбар
7	Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх	14 асуулгын хуудасны 8-д буюу 57.2 хувьд хангалттай	Хүлээх танхимын зай, сандлын тоо хангалттай.
8	Дорнод аймаг дахь Сум дундын I шүүх	10 асуулгын хуудсанд 100 хангалтгүй	Хүлээх танхим зай багатай, хүн суух сандал хүрэлцээгүй байна.
9	Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүх	22 асуулгын хуудасны 2-т буюу 9.1 хувьд хангалттай хариулжээ.	Хүлээлгийн сандлын хүрэлцээ хангалтгүй.

Хот болон хөдөө, орон нутаг дахь шүүхүүдийн аль алинд нь хүлээлгийн танхимын зай багтаамж багатай, үүдний коридорт хэдэн сандал тавих замаар хүлээлгийн танхим бий болгосон нь ажиглагдлаа.

Шүүхийн байрыг хүндэтгэл, төрүүлэхүйц байлгахын тулд нэгдсэн стандартаар, тухайлбал, нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн байрны стандартаар засварлан тохижуулах ажлыг зохион байгуулах хэрэгтэй.

2.4.4. Шүүхийн байр, шүүх хуралдааны танхимын хүндэтгэл төрүүлэхүйц, цэвэр тохилог байдал

► Ажиглалтын дүн

Шүүхийн байр ариун цэврийн эрүүл ахуйн стандарт, эрүүл ахуйн зохистой хэм хэмжээг хангасан байх нь шүүхийн дотоод зохион байгуулалтыг эмх цэгцтэй болгохоос гадна шүүхэд хандсан, шүүн таслах үйл ажиллагааг ажиглахаар ирсэн иргэдэд хүндлэл төрүүлж, эерэг уур амьсгал бүрдүүлдэг.

Шүүхийн байрны талаарх ажиглалтын дүнг дараах хүснэгтэд харуулав.

№	Шүүхийн нэр	Шүүхийн байр цэвэр тохилог эсэх талаар	
		Асуулгад хариулсан байдал ²⁰	Тайлбар
1	Баянгол дүүргийн шүүх	32 асуулгын хуудасны 28-д буюу 87.5 хувьд нь тохилог	Тохилог байдал харьцангуй сайн
2	Баянзүрх дүүргийн шүүх	42 асуулгын хуудасны 28 буюу 66.7 хувьд тохилог	Тохилог байдал дунд зэрэг

²⁰ Хавсралт /Ажиглагчдын асуулгад хариулсан байдлыг зөвхөн хүчинтэй санал асуулгын хуудасны дүнгээр тооцон дүгнэсэн/-аас харна уу.

№	Шүүхийн нэр	Шүүхийн байр цэвэр тохилог эсэх талаар	
		Асуулгад хариулсан байдал	Тайлбар
3	Сүхбаатар дүүргийн шүүх	44 асуулгын хуудасны 28-д буюу 66.7 хувьд тохилог	Шүүхийн байр нь хуучирч элэгдсэн. Тохилог байдал дунд зэрэг.
4	Сонгинохайрхан дүүргийн шүүх	56 асуулгын хуудасны 24-т буюу 42.8 хувьд тохилог	Тохилог байдал муу
5	Хан-Уул дүүргийн шүүх	29 асуулгын хуудасны 11-д буюу 36.6 хувьд тохилог	Тус шүүхэд ажиглалт хийж байх үед шүүхийн байранд засвар хийгдэж байсан учир тоос шороо, дуу чимээ ихтэй байв.
6	Чингэлтэй дүүргийн шүүх	29 асуулгын хуудасны 18-д буюу 62.1 хувьд нь тохилог	Тохилог байдал дунд зэрэг. Шүүхийн байр хуучирч муудсан, засвар тохижилт хийгдээгүй.
7	Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх	14 асуулгын хуудасны 9-д буюу 64.3 хувьд нь тохилог	Тохилог байдал дунд зэрэг.
8	Дорнод аймаг дахь Сум дундын I шүүх	10 асуулгын хуудасны 9-д буюу 90 хувьд тохилог	Тохилог байдал харьцангуй сайн.
9	Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүх	22 асуулгын хуудсанд 100 хувь тохилог гэж хариулсан.	Шүүхийн байр тохилог

Нийт ажиглалтын асуулгын 33.8 хувьд шүүхийн байр тохилог биш гэж үзсэн байна.

Шүүх хуралдааны танхимын тухайд

№	Шүүхийн нэр	Шүүх хуралдааны танхим хүндэтгэл төрүүлэхүйц, цэвэр тохилог эсэх талаар	
		Асуулгад хариулсан байдал	Анхаарал татсан асуудал
1	Баянгол дүүргийн шүүх	32 асуулгын хуудасны 23-т буюу 71.9 хувьд хүндэтгэл төрүүлэхүйц, тохилог	Тохилог байдал дунд зэрэг.
2	Баянзүрх дүүргийн шүүх	42 асуулгын хуудасны 23-т буюу 56.1 хувьд хүндэтгэл төрүүлэхүйц, тохилог	Тохилог байдал дунд зэрэг.
3	Сүхбаатар дүүргийн шүүх	43 асуулгын хуудасны 37-д буюу 84.1 хувьд хүндэтгэл төрүүлэхүйц, тохилог	Тохилог байдал харьцангуй сайн

№	Шүүхийн нэр	Шүүх хуралдааны танхим хүндэтгэл төрүүлэхүйц, цэвэр тохилог эсэх талаар	
		Асуулгад хариулсан байдал	Анхаарал татсан асуудал
4	Сонгинохайрхан дүүргийн шүүх	56 асуулгын хуудасны 52-т буюу 92.9 хувьд хүндэтгэл төрүүлэхүйц, тохилог	Тохилог байдал харьцангуй сайн
5	Хан-Уул дүүргийн шүүх	29 асуулгын хуудасны 10-т буюу 34.5 хувьд хүндэтгэл төрүүлэхүйц, тохилог	Засвар хийж байсан
6	Чингэлтэй дүүргийн шүүх	29 асуулгын хуудасны 22-т буюу 75.9 хувьд хүндэтгэл төрүүлэхүйц, тохилог	Тохилог байдал дунд зэрэг
7	Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх	14 асуулгын хуудасны 12-т буюу 85.8хувь-д нь шүүх хуралдааны танхим хүндэтгэл төрүүлэхүйц, тохилог гэж хариулсан.	Тохилог байдал харьцангуй сайн
8	Дорнод аймаг дахь Сум дундын I шүүх	10 асуулгын хуудасны 8-д буюу 80 хувьд хүндэтгэл төрүүлэхүйц, тохилог	Тохилог байдал харьцангуй сайн
9	Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүх	22 асуулгын хуудасны 100 хувьд нь хүндэтгэл төрүүлэхүйц, тохилог гэж хариулжээ	Тохилог байдал маш сайн

Тохилог байдлын хувьд харилцан адилгүй байна. Энэ нь тухайн шүүхийн Тамгын газрын үйл ажиллагаанаас бүрэн хамаарах бөгөөд шүүхийн үйл ажиллагааг гаднаас нь харж дүгнэх чухал үзүүлэлтүүдийн нэг юм. Дүгнэлтэд Хан-Уул дүүргийн шүүхэд засвар хийж байсантай холбоотойгоор ерөнхий нөхцөл байдал муу гэж гарсан болохыг анхаарна уу.

Шүүхийн байрыг хүндэтгэл төрүүлэхүйц байлгахын тулд нэгдсэн стандартаар, тухайлбал, нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн байрны стандартаар засварлан тохижуулах ажлыг зохион байгуулахыг Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн ажлын алба шийдвэрлэх нь зүйтэй.

Шүүх хуралдааны ажиглалтын тухай ойлголт

Шүүх хуралдааны ажиглалт гэж юу вэ?

Шүүх хуралдааны ажиглалт нь хүний эрхийн мониторингийн нэг хэлбэр юм.

Хүний эрхийн мониторинг нь олон улсын хүний эрхийн стандартуудыг дотоодын нөхцөл байдал хэрхэн хангаж байгааг баримтад тулгуурлан магадлах замаар хүний эрхийн асуудалд дүн шинжилгээ хийх ажиллагаа юм.

Шүүхийн мониторинг нь шүүхийн үйл ажиллагааны ил тод, шударга, бие даасан, хариуцлагатай, бүтээмжтэй байдлыг нэмэгдүүлэхэд онцгой ач холбогдолтой.

Шүүхийн ажиглалт нь олонхи тохиолдолд олон улсын ажиглагчид аль нэг улсын шүүх хуралдаанд сууж тухайн шүүх хэр шударга ажиллаж байгаа талаар дүн шинжилгээ хийх хэлбэрээр явагддаг. Тухайлбал, тухайн улсад шударга ёс хэрхэн тогтож байгааг, шүүгч, шүүхийн ажилтан, прокурор, өмгөөлөгч, цагдаагийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны мэргэжлийн болон ёс зүйн түвшинг үнэлэх аргаар явагддаг. Ийм ажиглалтыг НҮБ, Эмнести Интернэшнл, Норвегийн Хүний Эрхийн Хүрээлэн, Хүний Эрхийн Хуульчдын Хороо, Олон Улсын Хельсинкийн Хороо, Америкийн Барын Холбоо зэрэг олон улсын байгууллага явуулдаг бөгөөд өөрсдийн өвөрмөц арга зүйтэй.

Олон улсын хэмжээнд шүүхийн ажиглалт нь дараах үндсэн чиг үүрэгтэй байдаг:

1. Шүүхийн шинэтгэлийн өмнө тулгарч буй асуудлыг тодорхойлох;
2. Шүүх хуралдааны нээлттэй байдлыг хянах;
3. Шүүх хуралдааны оролцогчдын идэвхи, чадавхийг нэмэгдүүлэх.

Шүүхийн мониторинг/ажиглалтыг түвшингээр нь олон улсын, үндэсний, орон нутгийн гэж ангилдаг бөгөөд аливаа мониторингийн нэгэн адил зохих нөлөөллийн үйл ажиллагаагүйгээр үр дүнд хүрэх боломжгүй юм. Улс бүр өөрийн эрх зүйн тогтолцоо, онцлогт тохируулан шүүхийн ажиглалтыг өөр өөр арга хэлбэрээр явуулдаг.

Шүүхийн ажиглалтын хэлбэрүүд нь:

- **Системийн ажиглалт** - Шүүхийн ил тод байдал, шүүгчийн ёс зүй гэх мэт системийн хувьд анхаарал татсан асуудлыг өргөн хүрээнд авч үзэхийг зорьдог;
- **Тодорхой хэрэг буюу кейсийн мониторинг** – олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүнд, дадлага туршлага бүхий шинжээчид онц ноцтой болон хохирогч шүүгдэгчийн хувийн онцлогоос хамаарч шударга шүүх үйл ажиллагаанд эргэлзээ үүсэх магадлал бүхий хэрэгт хийдэг.
- **Хэвлэл мэдээллээр дамжуулан хийх мониторинг** - хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, сэтгүүлчид мэргэжлийн харьцангуй өндөр түвшинд хараат бусаар ажиллаж чаддаг нөхцөлд л хэрэгжих боломжтой.

Шүүхийн ажиглагч гэж хэн бэ?

Шүүхийн ажиглагчдын үндсэн ажил нь зөвхөн ажиглах бөгөөд ажигласнаа үнэн зөвөөр цаасан дээр буулгах үүрэгтэй. Хэдийгээр энэ нь энгийн хялбар мэт харагдах боловч тухайн хүнээс ихээхэн ур чадвар, хариуцлага шаарддаг. Энэхүү хариуцлагатай ажлыг гүйцэтгэх ажиглагч нь дараах шалгуурыг хангасан байх ёстой:

1. Эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн талаар зохих мэдлэгтэй байх;
2. Хүний эрхийн олон улсын болон дотоодын стандартын талаар зохих ойлголт, мэдлэгтэй байх;
3. Олон улсын болон өөрийн улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан шударга шүүхийн стандартын талаар нэгдсэн ойлголтой байх;
4. Хараат бусаар ажиглалт хийх ёс зүйн шалгуурыг хангасан байх.

Шүүхийн ажиглагчийн баримтлах зарчим

Шүүхийн ажиглалтын үндсэн зарчим нь шүүн таслах ажиллагааны хараат бус байдлыг дээдлэх явдал юм. Иймээс шүүхийн ажиглагчид энэхүү зарчмыг удирдлага болгон ажиллах ба дараах зүйлийг хориглодог:

- Ажиглалт хийх явцдаа ямар ч тохиолдолд шүүн таслах ажиллагаанд оролцох буюу хуралдааныг ямар нэг хэлбэрээр тасалдуулах ёсгүй;
- Шүүгч, шүүх бүрэлдэхүүнд хэргийн болон шүүх хуралдааны явцын талаар санал, дүгнэлт хэлж, асуулга шаардлага тавьж болохгүй. Хэрэв ажиглагчид шүүх, шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн ажиллагааг шүүмжлэх, сайшаах тохиолдолд зөвхөн тайланд бичиж, үүнийгээ төслийн зохицуулагчид мэдэгдэх үүрэгтэй.
- Голч, төвийг сахисан байх ёстой. Аль нэг талыг дэмжиж туслалцаа үзүүлэх ёсгүй. Шүүгч, прокуророос хэргийн талаар мэдээлэл авахаар уулзах тохиолдолд үзэл бодлоо илэрхийлж болохгүй. Ажиглагч хэргийн гэрч, хохирогч, шүүгдэгчийн ар гэрийнхэн, шүүх хуралдааны бусад оролцогчтой харилцаж болохгүй. Шүүх хуралдааны болон хэргийн оролцогчид ажиглагчаас эрх зүйн туслалцаа хүссэн тохиолдолд өөрсдийн үл оролцооны байр суурийг тодорхой илэрхийлж, шаардлагатай бол тухайн орон нутгийн төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн туслалцааны төвд ханд хэмээн зөвлөж болно.
- Ажиглалт хийх үедээ зөв зохистой, шүүхэд хүндэтгэлтэй байдлаар хувцасласан байх бөгөөд шүүгч болон шүүх бүрэлдэхүүнд ямагт хүндэтгэлтэй хандах ёстой. Ажиглагч нь шүүгч, шүүхийн ажилтнуудтай зохисгүй, бүдүүлэг харьцахыг, шүүхийн байрны дотоод журмыг үл тоомсорлох, биеэ зохисгүй авч явахыг хориглоно.
- Ажиглалтын үр дүнг асуулгад хариулах хэлбэрээр, зохих зааврын дагуу ойлгомжтой, цэгцтэй тэмдэглэх ба ажиглагдсан зарим ноцтой, хууль бус үйлдлийг дэлгэрэнгүй тайлбартайгаар бичиж тэмдэглэх ёстой. Ажиглалтын үр дүнд олж авсан мэдээлэлд дүгнэлт хийхдээ анхааралтай байж, хүний эрхийг зөрчсөн үйлдэл, давж заалдах үндэслэл болох алдааг ангилах нь зүйтэй. Шүүн таслах ажиллагааны алдаа бүрийг хүний эрхийн зөрчил гэж үзэж болохгүй.
- Ажиглалтын үүргийг гүйцэтгэх явцад олж авсан бүхий л мэдээллийн нууцлалыг чанд сахина. Мөн хэргийн гэрч, шүүгдэгчээс бусад оролцогчийн нэрийг нууцална.
- Ажиглагч нь шүүхийг буруутгах, аливаа байдлаар шүүмжлэхийг зорилгоо болгохгүй байх ёстой.
- Бодит мэдээллийг олж авахыг зорих ба шүүхийн алдаатай талыг дөвийлгөж, нэг талыг харахгүй байх ёстой.

Шударга шүүхийн тухай ойлголт

Шударга шүүхийн стандарт²⁴

...Та өөрийгөө шүүхийн танхимд ямар учраас гэдгээ ч мэдэхгүй сууж байна гээд төсөөл дөө. Таныг өмнө нь хэзээ ч гэмт хэрэг гэж тооцдоггүй байсан үйлдэлд буруутган ял сонсгож эхлэхэд та бүр учраа олохоо байна. Хэн ч таны тавьсан асуултад хариулахгүй. Өмгөөлөгч байхгүй учраас та хүчин мөхөсдөж яахаа мэдэхээ болино. Тэгтэл байдал бүр дордож гэрчийн мэдүүлэг авч эхлэхэд таны мэдэхгүй хэлээр хэн нэгэн мэдүүлэг өгч танд орчуулж өгөх орчуулагч байхгүй байна. Шүүх хуралдааны явцаас энэ нь эхний ч биш бүр хоёрдох удаагийн хурал бөгөөд өмнөх нь таныг оролцуулахгүйгээр явагдсан гэдгийг олж мэднэ. Ингээд шүүх хурал цааш үргэлжлэх тусам хүн бүр өөрийг тань гэм буруутайд тооцож байгаа бөгөөд гагцхүү ямар ял оноохыг шийдэх нь гол асуудал юм байна гэдгийг ойлгоно...

Дээрх нөхцөл байдал нь эрх зүйт төрийн гол тулгуур зарчмын нэг болох шударга шүүхийн стандарт алдагдах нь юунд хүргэж болохыг харуулж байгаа юм.

Төрөөс гэмт хэрэгт холбогдсон хүнд зохих хариуцлага хүлээлгэх тохиолдолд хувь хүн өөрийн эрх, эрх чөлөөгөө хязгаарлуулах, эсвэл ямар нэгэн байдлаар эрхээ зөрчүүлэх эрсдэлтэй тулгардаг. Шударга шүүхээр шүүлгэх эрх нь тэдгээр хүмүүсийг хууль бусаар хариуцлага хүлээхээс сэргийлэх хамгаалалт юм.

Хувь хүн эрүүгийн хэрэгт холбогдон шүүхийн хаалга татахад тэр хүн ганцаараа бүхэл бүтэн төрийн машины өмнө очиж байна гэсэн үг. Хэн нэгнийг гэмт хэрэгт буруутгасан үед түүнтэй хэрхэн харьцсан байдлаас тухайн улсад хүний эрх хэрхэн хэрэгжиж байгааг харж болдог. Хууль сахиулах байгууллагын ажилтан хүнийг эрүүдэн шүүх буюу хэрцгий харьцах, гэм буруугүй этгээдэд хилсээр ял эдлүүлэх, шүүх илэрхий шударга бус шийдвэр гаргах, эсхүл шударга бус байдал бий болгох тохиолдолд шүүхийн нэр хүнд, түүнд итгэх иргэдийн итгэл үгүй болдог. Улс бүр гэмт хэрэг үйлдсэн этгээдэд зохих хариуцлагыг шударгаар оногдуулах үүрэгтэй боловч тэр этгээд шударга бус шүүхээр хэргээ шийдвэрлүүлсэн тохиолдолд шударга ёс алдагддаг.

Гэмт хэрэг илрүүлэх үүрэг бүхий албан тушаалтан хүнийг гэмт хэрэгт сэрдэж, сэжиглэхээс эхлээд баривчлах, урьдчилан хорих, бүх шатны шүүхээр хэрэг шийдвэрлэгдэх, ял эдлэхэд хүний эрх зөрчигдөх эрсдэл оршиж байдаг. Иймээс олон улсын хүний эрхийг хамгаалагчид энэ бүх шатанд хүний эрхийг хамгаалах зорилгоор бүх нийтээрээ дагаж мөрдөх шударга шүүхийн стандартыг боловсруулан гаргажээ.

Шударга шүүхээр шүүлгэх эрх нь хүний үндсэн эрх юм. Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалд тусгагдсан энэхүү зарчим олон улсын түвшинд нэгэнт заншлын хэм хэмжээ болон тогтжээ. Шударга шүүхээр шүүлгэх эрх нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 онд баталсан Иргэний болон Улс төрийн эрхийн пактаар илүү тодорхой томъёологдож, дахин баталгаажсан юм. Энэхүү пакт НҮБ болон бүс нутгийн олон улсын байгууллагуудын олон тооны гэрээ, гэрээнээс бусад бичиг баримтад

²⁴ Олон улсын Эмнести Интернэшнл байгууллагын Шударга шүүхийн гарын авлагаас хэсэгчлэн орчуулав. Amnest International Fair Trials Manual <http://www.amnesty.org/en/library/info/POL30/002/1998>

мөн тусгагдаж хүлээн зөвшөөрөгдсөн байна. Тийм учраас шүүхэд мониторинг хийх үйл ажиллагаа нь хүний эрхийг хамгаалах олон улсын хичээл зүтгэлийн нэгэн чухал хэсэг болж байна. Шүүхийн үйл ажиллагааг ажиглах эрх нь шударга, ил тод шүүхтэй байх эрхээс урган гардаг. Ил тод шүүхтэй байх эрх нь олон улсын болон бүс нутгийн олон тооны гэрээ хэлэлцээрт тусгагдсан зарчим юм.

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалд “хүн бүр шударга, ил тод шүүхээр шүүлгэх эрхээр ижил хангагдах” ба “эрүүгийн хэрэгт татагдсан хүн бүр нээлттэй шүүхээр хэргээ шүүлгэж, гэм буруутай нь тогтоогдох хүртэл гэмт хэрэгтнээр тооцогдохгүй байх эрхтэй” гэж заасан байна. Нээлттэй шүүхээр шүүлгэх эрх нь шүүгдэгчид эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад шударга шүүхээр шүүлгэх, эрхээ хамгаалах боломж олгодогдоос гадна шүүх хэргийг шударгаар шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж, шүүгч, яллагчид өөрсдийн үйл ажиллагааг шударга, мэргэжлийн түвшинд явуулахад нөлөөлдөг. Нээлттэй шүүх үйл ажиллагаа үнэнийг нарийвчлан тогтоож, гэрчийн мэдүүлэг өгөхөд анхаараад зогсохгүй шүүх хуралдааны талаар мэдээлэл олж авах олон нийтийн ашиг сонирхлыг давхар хамгаалж байдаг. Олон нийт шударга байдал хэрхэн тогтож байна вэ, шүүх хуралдаан ямар шийдвэрт хүрэв гэдгийг мэдэх эрхтэй байдаг.

Тодорхой хэргийг шийдвэрлэсэн тухайн улсын практик хуультайгаа хэр нийцэж байна вэ, тэрхүү практик болон хууль нь гэрээгээр болон гэрээний бус хэм хэмжээгээр баталгаажсан олон улсын стандартад нийцэж байна уу гэдгийг тогтооход энэхүү үнэлгээний зорилго орших юм.

Шударга шүүхийн зарчим нь дараах бүрэлдэхүүн элементүүдтэй байна:

1. Шүүхээс өмнөх шат;
2. Шүүхийн шат;
3. Онцгой субъектүүд болон нөхцөл байдал.

Шүүхийн өмнөх шатны эрх

1. Халдашгүй дархан байх эрх:
 - Хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах болон хөөн зайлуулж үл болно.
 - Шүүхийн өмнөх шатанд чөлөөтэй байх эрх.
2. Цагдан хоригдсон хүн мэдээлэл авах эрх:
 - Баривчлагдсан болон саатуулагдсан шалтгааныг цаг алдалгүй мэдэгдэх;
 - Баривчлагдсан иргэнд эрхийг нь тайлбарлаж өгөх (үүнд өмгөөлөл авах эрхийг онцгойлон мэдэгдсэн байх ёстой);
 - Ямар гэмт хэрэгт буруутгагдаж байгаа тухай цаг алдалгүй мэдэгдэх;
 - Тухайн этгээдийн мэддэг хэл дээр ойлгомжтой мэдэгдэх.
3. Шүүхийн өмнөх шатанд эрх зүйн туслалцаа авах эрх:
 - Өмгөөллийн туслалцаа авах эрх;
 - Өмгөөлөгчөө өөрөө сонгох эрх;
 - Төлбөрийн чадваргүй тохиолдолд үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ авах эрх;
 - Албадан саатуулагдсан этгээд өмгөөлөгчтэйгээ уулзах эрх;
 - Өмгөөлөгчтэйгээ уулзах цаг болон байраар хангагдах эрх;
 - Өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах боломжоор хангагдах эрх.
4. Албадан саатуулагдсан иргэн гадаад ертөнцтэй харилцах эрх:
 - Гадаад ертөнцтэй харилцаж, эргэлт авах эрх;
 - Албадан саатуулагдсан этгээд гэр бүлийнхэндээ баривчлагдсан болон саатуулагдсан тухайгаа мэдэгдэх эрх;
 - Гэр бүлийнхэнтэйгээ уулзах эрх;

- Гадаадын иргэн бол өөрийн орны төлөөлөгчтэй уулзах эрх;
 - Эмнэлгийн тусламж авах эрх.
5. Шүүхийн өмнө цаг алдалгүй очиж хэргээ шийдүүлэх эрх;
 6. Өөрийн албадан саатуулагдсан нь хууль ёсны эсэхийг шалгуулах эрх;
 7. Аль болох хурдан хугацаанд шүүх хуралдааныг явуулах буюу шүүх хуралдаан болтол сул чөлөөтэй байх эрх;
 8. Өөрийгөө өмгөөлөхөд шаардлагатай хугацаа болон боломжоор хангагдах эрх.
 9. Байцаалтын үед эдлэх эрхүүд:
 - Байцаагдаж байгаа хүмүүсийн аюулгүй байдал;
 - Хүчлэн хэрэг тулгагдахаас ангид байх эрх;
 - Мэдүүлэг өгөхгүй байх эрх;
 - Хэлмэрч авах эрх;
 - Байцаалтын тэмдэглэл хөтлүүлэх эрх;
 - Байцаалтыг тогтоосон журмын дагуу явуулах;
 10. Хүнлэг орчинд хоригдох буюу аливаа эрүүдэн шүүлтээс ангид байх эрх.

Шүүхийн шатан дахь эрх

- Хууль ба шүүхийн өмнө эрх тэгш байх эрх;
- Хуулийн дагуу байгуулагдсан, бүрэн эрхт, хараат бус, шударга шүүх байгууллагаар хэргээ хянан шийдвэрлүүлэх эрх;
- Шүүх хуралдааныг шударга явуулах эрх;
- Шүүх хуралдааныг нээлттэй явуулах эрх;
- Гэм буруугүйд тооцогдох эрх;
- Албадуулан гэм буруугаа хүлээхгүй байх буюу гэрчийн мэдүүлэг өгөхгүй байх эрх;
- Эрүүгийн хуулийг буцаан хэрэглүүлэхгүй байх ба давхар ял хүлээхгүй байх;
- Шүүх хуралдааныг хойшлуулахгүй явуулах эрх;
- Өөрөө өөрийгөө буюу өмгөөлөгчөөр дамжуулан өмгөөлүүлэх эрх;
- Анхан болон давж заалдах шатны шүүх хуралдаанд биечлэн оролцох эрх;
- Гэрчийг дуудуулах ба шалгуулах эрх;
- Хэлмэрч ба орчуулгын үйлчилгээ авах эрх;
- Шүүхээр хууль ёсны, үндэслэлтэй шийдвэрлүүлэх эрх;
- Шударга шийтгэл хүлээх эрх;
- Давж заалдах эрх.

Дээрх эрхүүд нь шударга шүүхийн олон улсын стандартад, мөн олон улсын гэрээний болон заншлын эрх зүйн хүрээнд нэлээд дэлгэрэнгүй тусгагдсан бөгөөд олон улсын баримт бичгүүдийг тухайлан дурдвал:

- Олон улсын иргэний болон улстөрийн эрхийн пакт;
- Олон улсын иргэний болон улстөрийн эрхийн пактын 1 дүгээр нэмэлт протокол;
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц;
- Эмэгтэйчүүдийг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхагдахаас сэргийлэх конвенц;
- Хүүхдийн эрхийн конвенц;
- Женевийн 4 дүгээр конвенц;
- Баривчлагдсан болон хоригдож байгаа хүмүүсийн эрхийг хамгаалах зарчмууд (Body of principles) /1988 он/;

- Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм (Standard Minimum Rules) /1955 он/;
- НҮБ-ын хуульчдын зарчим /1990 он/;
- Прокурорын үйл ажиллагааны удирдамж /1990 он/;
- Шүүхийн хараат бус байдлын суурь зарчмууд /1985 он/;
- Хууль бусаар баривчлах ажиллагааны эсрэг ажлын хэсэг /1991 онд байгуулагдсан/;
- Хүч хэрэглэж сураггүй алга болгохын эсрэг ажлын хэсэг /1980 онд байгуулагдсан/;
- Тусгай илтгэгчид:
 - Шүүхээс гадуур шийтгэл оноохын эсрэг;
 - Эрүүдэн шүүхийн эсрэг;
 - Шүүгчид, хуульчдын хараат бус байдлын зарчим;
- Хууль хэрэгжүүлэгч байгууллагын ажилтнуудын хүч, галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчим;
- Бээжингийн тунхаглал;
- Хууль хэрэгжүүлэгч байгууллагын ажилтнуудын ёс зүйн дүрэм;
- Эрүүдэн шүүхтэй холбоотой эмч нарын зарчим;
- Олон улсын эрүүгийн шүүхийн тухай Ромын дүрэм /2002/;
- Хорихоос бусад арга хэмжээ авахад баримтлах наад захын жишиг дүрэм /Токиогийн дүрэм 1990/;
- Гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүүхэдтэй харилцах наад захын жишиг дүрэм / Бээжингийн дүрэм 1985/;
- Эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүүхдийн эрхийг хамгаалах журам.

Олон улсын баримт бичигт заасан стандартуудыг Монгол Улс нэгдэн орсон болон соёрхон баталсан тохиолдолд холбогдох дотоодын хууль тогтоомждоо тусгаж бататгах ёстой ба хэрэв хууль тогтоомжид тусгагдаагүй бол Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3-т заасны дагуу Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ. Тиймээс хуульчид Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний холбогдох заалтуудыг үр ашигтайгаар хэрэглэх хэрэгтэй юм.

Шударга шүүхийн стандарт үндэсний хууль тогтоомжид хэрхэн туссаныг судлахад Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд дараах байдлаар тусгагджээ. Үүнд:

Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлэгт:

- Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй;
- Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно;
- Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй;
- Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүнийгэрбүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ;
- Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;
- Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уг эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхтэй;
- Бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй;
- Өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно;

- Өөрийгөө өмгөөлөх эрхтэй;
- Хууль зүйн туслалцаа авах эрхтэй;
- Нотлох баримтыг шалгуулах эрхтэй;
- Шударга шүүхээр шүүлгэх эрхтэй;
- Хэргээ шүүх ажиллагаанд биечлэн оролцох эрхтэй;
- Шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй;
- Уучлал хүсэх эрхтэй;
- Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно;
- Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд:

- Шүүх хуралдаан хуульд зааснаас бусад тохиолдолд нээлттэй байна;
- Шүүхийн тогтоол гарах хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй;
- Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэй, яллагдагч, шүүгчдэгчийн гэм буруутай эсэхэд, түүнчлэн Эрүүгийн хууль болон Эрүүгийн Байцаан шийтгэх хуулийг хэрэглэх болон тайлбарлахад эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгчдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ;
- Монгол Улсад хүн бүр үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна;
- Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдана. Албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно;
- Шүүн таслах ажиллагаа талуудын эрх тэгш байдал мэтгэлцээний үндсэн дээр явагдана;
- Сэжигтэн, яллагдагч, шүүгчдэгчийн өмгөөлүүлэх эрх;
- Шүүх хуралдаанд иргэний төлөөлөгч оролцуулах;
- Өмгөөлөгч заавал оролцуулах;
- Шүүгч, прокурор, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, орчуулагч хэлмэрчийг татгалзан гаргах эрх;
- Шүүх хуралдааныг тасралтгүй явуулна;
- Хэргийг нэг бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэнэ;
- Хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой судална;
- Шүүхэд хэрэг хэлэлцэх ажиллагаа нь зөвхөн шүүгчдэгчийн хувьд гагцхүү түүнийг шүүхэд шилжүүлсэн хэргийн хэмжээний дотор явагдана;
- Нотлох баримтыг үнэлэх

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон Монгол Улсын хууль тогтоомжоор баталгаажсан шударга шүүхийн стандартын хэрэгжилтийг шүүхийн ажиглалтын замаар бүгдийг нь бүрэн гүйцэд үнэлэх аргагүй юм.

Шүүх хуралдааны ажиглалтын хуудас

Ажиглагчдын мэдээлэл:

Код:

- _____
- _____

А. Шүүх хуралдааны ерөнхий мэдээлэл:

- Шүүхийн ажиглалтын огноо: _____
- Аль дүүрэг/аймгийн шүүх: _____
- Шүүх хуралдаан нь:
 - Анхны удаа
 - Буцсан хуралдаан
- Шүүх хуралдааны хуваарьт цаг: _____
- Шүүх хуралдаан эхэлсэн цаг: _____
- Шүүх хуралдаан дууссан цаг: _____
- Шүүх хуралдаан хойшилсон эсэх: *Тийм* *Үгүй*
- Шүүх хуралдаан хойшлогдсон бол хэнээс шалтгаалсан бэ (шалтгааныг бичнэ үү)?
 - Шүүх _____
 - Шүүгч _____
 - Улсын яллагч _____
 - Өмгөөлөгч _____
 - Бусад оролцогч _____
 - Тодорхойгүй _____
- Хойшилсон шалтгааныг хэн танд мэдээлсэн бэ? _____
- Хойшилсон шалтгааныг хэзээ мэдээлсэн бэ? _____
- Хойшилсон шалтгааныг урьдчилан мэдэгдэх боломжтой байсан эсэх?
Тийм *Үгүй*
- Шүүх хуралдаан нээлттэй явагдсан эсэх: *Тийм* *Үгүй*
- Үгүй бол шалтгаан: _____
- Нээлттэй шүүх хуралдаанд оролцох хүсэлтэй хүн болгоныг оруулсан эсэх:
Тийм *Үгүй*
- Үгүй бол ямар шалтгаанаар: _____
- Нээлттэй шүүх хуралдаанд оролцоход зөвшөөрөл шаардлагатай байсан эсэх?
Тийм *Үгүй*
- Нээлттэй шүүх хуралдаанд оролцох зөвшөөрлийг хэнээс авсан? _____
- Хэргийн зүйлчлэл: _____

Б. Шүүх хуралдааны оролцогчдын талаар мэдээлэл

1. Шүүх бүрэлдэхүүн (доорх хариултаас сонгож тэмдэглэнэ үү):
 - а) 1 шүүгч
 - б) Шүүх бүрэлдэхүүн
2. Шүүх хуралдааны даргалагчийн овог нэр: _____
Шүүгчийн овог нэр _____
Шүүгчийн овог нэр _____
3. Шүүгдэгчийн мэдээлэл:
Овог нэр: _____
Иргэний харьяалал: _____
Өмнө ял эдэлж байсан эсэх: _____
Боловсрол/Мэргэжил: _____

Овог нэр: _____
Иргэний харьяалал: _____
Өмнө ял эдэлж байсан эсэх: _____
Боловсрол/Мэргэжил: _____

Овог нэр: _____
Иргэний харьяалал: _____
Өмнө ял эдэлж байсан эсэх: _____
Боловсрол/Мэргэжил: _____
3. Улсын яллагчийн овог нэр: _____
4. Харьяалал: _____
5. Шүүгдэгчийн өмгөөлөгч оролцсон эсэх: Тийм Үгүй
6. Өмгөөлөгчийн овог нэр: _____
Өмгөөлөгчийн овог нэр: _____
Өмгөөлөгчийн овог нэр: _____
7. Шүүгдэгч өмгөөлөгчөө өөрөө сонгосон эсэх: Тийм Үгүй
8. Өмгөөлөгчийг төрөөс томилсон эсэх: Тийм Үгүй
9. Хохирогчийн өмгөөлөгч оролцсон эсэх: Тийм Үгүй
10. Өмгөөлөгчийн овог нэр: _____
11. Шүүгдэгч орчуулагч/ хэлмэрч авах хүсэлт гаргасан эсэх: Тийм Үгүй
12. Хүсэлтийг хангасан эсэх: Тийм Үгүй
Ямар хэлээр: _____
13. Шүүгдэгч, хохирогч, гэрч хэлгүй дүлий тохиодолд дохион хэлний хэлмэрч байсан эсэх? Тийм Үгүй
14. Шүүх хуралдаанд хохирогч оролцсон эсэх: Тийм Үгүй
15. Шүүх хуралдаанд яллах талын гэрч оролцсон эсэх Тийм Үгүй
16. Шүүх хуралдаанд цагаатгах талын гэрч оролцсон эсэх Тийм Үгүй
17. Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч оролцсон эсэх: Тийм Үгүй

В. Шүүх хуралдааны явц

1. Шүүгч шүүгдэгчийн биеийн байцаалтыг шалгасан эсэх: Тийм Үгүй
2. Доорх этгээдүүдийг татгалзан гаргах хүсэлт тавьсан эсэх:
 - а) Шүүгч Тийм Үгүй
 - б) Дагалдах шүүгч Тийм Үгүй
 - в) Бусад этгээд _____ Тийм Үгүй
3. Хэрэв тийм бол хүсэлтийг биелүүлсэн эсэх? _____
4. Шүүх хуралдааны тэмдэглэлийг шүүхийн нарийн бичгийн дарга ямар хэлбэрээр хөтлөсөн:
 - а) Гараар бичиж
 - б) Компьютерт шивэж
 - в) Аудио бичлэгээр
 - г) Видео бичлэгээр
 - д) Бусад
5. Шүүгдэгчийн эрх, үүргийг сануулсан эсэх:
 1. Ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх
 2. Яллах тогтоолтой танилцах
 3. Өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч авах
 4. Өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах
 5. Мэдүүлэг өгөх, өгөхөөс татгалзах
 6. Нотлох баримт гаргаж өгөх болон шалгуулах
 7. Хэргийн материалтай танилцах
 8. Шүүх хуралдаанд оролцох
 9. Шүүх хуралдааны оролцогчийн татгалзан гаргах
 10. ЭБША-ны талаар гомдол гаргах
 11. Шинжээчийн дүгнэлттэй танилцах
 12. Эх хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч хэлмэрч авах
 13. Шүүх хуралдаанд эцсийн үг хэлэх
 14. Шүүхийн тогтоолд гомдол гаргах
 15. Өөрийн эсрэг мэдүүлэг өгөх болон гэм буруутай эсэхээ нотлох үүрэг хүлээхгүй байх үүрэгтэй
 16. Шүүхээс дуудсан цагт ирэх үүрэгтэй
 17. Шүүх хуралдааны дэгийг сахих үүрэгтэй
 18. Шүүхийн шийдвэрт саад болохгүй байх үүрэгтэй
6. Шүүгч шүүх хуралдааны оролцогчдын эрх үүргийг ойлгомжтой байдлаар тайлбарлаж өгсөн эсэх: Тийм Үгүй
7. Яллагчийн уншиж сонгосон яллах дүгнэлт шүүгдэгчийн гардаж авсантай таарч байгааг тодруулсан эсэх: Тийм Үгүй
8. Нотлох баримтыг ямар хэлбэрээр танилцуулсан бэ?
 - а) Материаллаг нотлох баримтыг гаргаж үзүүлэх хэлбэрээр
 - б) Гэрчийн мэдүүлгийг унших хэлбэрээр
 - в) Шинжээчийн дүгнэлтийг унших хэлбэрээр
 - г) Гэрчийг шууд байцаах хэлбэрээр
 - д) Шинжээчийг шууд байцаах хэлбэрээр
 - е) Бусад хэлбэрээр

9. Шүүгдэгч болон түүний өмгөөлөгчдөд доорх боломж байсан эсэх:
- | | | |
|--|------|------|
| а) Хэргийн материалтай танилцах | Тийм | Үгүй |
| б) Яллагчийн нотлох баримт, фактын талаар асуулт тавих | Тийм | Үгүй |
| в) Гэрч болон шинжээчийг байцаах | Тийм | Үгүй |
| г) Шинээр нотлох баримт танилцуулах | Тийм | Үгүй |
10. Ажиглагчийн дүгнэж байгаагаар шүүх хуралдааны үеэр талууд идэвхитэй мэтгэлцсэн эсэх:
- | | | |
|--|------|------|
| | Тийм | Үгүй |
|--|------|------|

Г. Шүүхийн шийдвэр:

1. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа ямар хугацаанд явагдав (хэрэг үүсгэснээс шүүхийн тогтоол гарах хүртэл)?
- | | |
|--------------------|------------------|
| а) 8 хоног хүртэл | ё) 6 сар хүртэл |
| б) 15 хоног хүртэл | ж) 9 сар хүртэл |
| в) 30 хоног хүртэл | з) 1 жил хүртэл |
| г) 45 хоног хүртэл | и) 1 жилээс илүү |
| д) 60 хоног хүртэл | к) тодорхойгүй |
| е) 3 сар хүртэл | |
2. Шүүхийн шийдвэрийн агуулга:
- а) Шүүгдэгчийг цагаатгасан
- б) Шүүгдэгчийг гэм буруутайд тооцож ял оноосон
- в) Шүүгдэгчийг гэм буруутайд тооцсон боловч Өршөөл үзүүлэх тухай хуулийн дагуу ялыг өршөөн хэлтрүүлсэн
- г) Хавтаст хэргийг нэмэлт мөрдөн байцаалтанд буцаасан
- д) Бусад _____
3. Ялын төрөл (ялын хэмжээг ард нь бичнэ үү):
- а) Торгох
- б) Үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах
- в) Эд хөрөнгө хураах
- г) Албадан ажил хийлгэх
- д) Баривчлах
- е) Хорих ял
- ё) Хорих ялыг тэнсэх
- ж) Бусад _____
4. Анхан шатны шүүхийн тогтоолд давж заалдах эрхийг сануулсан эсэх:
- | | | |
|--|------|------|
| | Тийм | Үгүй |
|--|------|------|
5. Шүүгч шүүхийн тогтоолыг шүүгдэгчдэд тайлбарлан ойлгуулсан эсэх:
- | | | |
|--|------|------|
| | Тийм | Үгүй |
|--|------|------|
6. Ажиглагчийн дүгнэж байгаагаар тогтоол нь:
- | | | |
|---|------|------|
| а) Хангалттай нотлох баримтад тулгуурлаж гарсан | Тийм | Үгүй |
| б) Хагас дутуу байдлаар үнэлж шийдвэр гарсан | Тийм | Үгүй |
7. Шүүгч, ажиглагчийн дүгнэж байгаагаар:
- | | | |
|--|------|------|
| а) Объектив байдлаар фактад тургуурлаж шийдвэр гаргасан | Тийм | Үгүй |
| б) Хараат бусаар аль нэг талд үйлчлэхгүйгээр гадны нөлөөнд автахгүйгээр шийдвэр гаргасан | Тийм | Үгүй |
| в) Талуудад адил тэгш боломж олгож байсан | Тийм | Үгүй |

Д. Шүүх болон шүүхийн ажилтнууд хүндэтгэл төрүүлэхүйц байсан эсэх

- | | | |
|---|------|------|
| 1. Шүүхийн байрны нөхцөл байдал таны ажигласнаар: | | |
| а) Байршил сайтай | Тийм | Үгүй |
| б) Хангалттай том зайтай | Тийм | Үгүй |
| в) Иргэдэд шаардлагатай мэдээллийг ил тавьсан | Тийм | Үгүй |
| г) Хүлээх танхимд хангалттай хүлээлгийн сандалтай | Тийм | Үгүй |
| в) Тохилог | Тийм | Үгүй |
| 2. Шүүх хуралдааны танхим хангалттай зайтай байсан эсэх: | Тийм | Үгүй |
| 3. Шүүх хуралдааны танхим цэвэр, тохилог, хүндэтгэл төрүүлэхүйц байсан эсэх: | Тийм | Үгүй |
| 4. Шүүх хуралдаанд оролцогчдын яриа харилцан сонсогдохуйц байсан эсэх: | Тийм | Үгүй |
| 5. Шүүгч өмсгөлөө өмссөн байсан эсэх: | Тийм | Үгүй |
| 6. Шүүх бүрэлдэхүүн орж ирэхэд шүүхийн танхимд байсан хүмүүс босож хүндэтгэл үзүүлсэн эсэх: | Тийм | Үгүй |
| 7. Шүүх хуралдааны дэгийг оролцогчдод тайлбарлаж таниулсан эсэх: | Тийм | Үгүй |
| 8. Шүүхийн танхимд дэг сахиулах цагдаа байсан эсэх: | Тийм | Үгүй |
| 9. Шүүхийн танхимын дэг зөрчигдөж байсан уу, тийм бол шүүгч ямар арга хэмжээ авсан бэ? | | |

Шүүх хуралдааны танхимд оролцогчдын суудал эзэлсэн байдал

(Ш) Шүүгч

(ДШ) Дагалдах шүүгч

(УЯ) Улсын яллагч

(Ө) Өмгөөлөгч

(ШН) Шүүхийн нарийн бичгийн дарга

(Хо) – Хохирогч

(ШЧ)- Шүүгдэгч

(ИТ) – Иргэдийн төлөөлөгч

(Хэ) - Хэлмэрч

10. Шүүхийн жижүүрийн иргэдтэй харилцах байдал таны ажигласнаар:
- а) Эелдэг, уриалгахан
 - б) Энгийн
 - в) Хөндий хүйтэн
 - г) Бүдүүлэг, дээрэнгүй
 - д) Ялгамжтай
 - е) Мэдэхгүй
11. Шүүхийн нарийн бичгийн даргын харилцаа таны ажигласнаар:
- а) Эелдэг, уриалгахан
 - б) Энгийн
 - в) Хөндий хүйтэн
 - г) Бүдүүлэг, дээрэнгүй
 - д) Ялгамжтай
 - е) Мэдэхгүй

12. Шүүхийн цагдаагийн харилцаа таны ажигласнаар:

- а) Эелдэг, уриалгахан*
- б) Энгийн*
- в) Хөндий хүйтэн*
- г) Бүдүүлэг, дээрэнгүй*
- д) Ялгамжтай*
- е) Мэдэхгүй*

13. Шүүгчийн шүүх хуралдааны оролцогч нартай харилцах байдал таны ажигласнаар:

- а) Эелдэг, уриалгахан*
- б) Энгийн*
- в) Хөндий хүйтэн*
- г) Бүдүүлэг, дээрэнгүй*
- д) Ялгамжтай*
- е) Мэдэхгүй*

Е. Ажиглагчийн зүгээс бусад хэлбэрээр анхаарал татсан асуудлууд:

Огноо/ Газар:

Ажиглагчийн гарын үсэг:

Ажиглагчийн гарын үсэг:

“Шүүхийн ажиглалт” – төсөлд оролцсон ажиглагчдын нэрс

Хөвсгөл аймаг:

1. Д.Лхагвацогт Хөвсгөл аймгийн Авилгалын эсрэг ТББ-ын эвсэл
2. Б. Мөнгөн-Эрдэнэ Улс Төрийн Боловсролын Академийн салбарын багш судлаач
3. Г. Цэцэн Хөвсгөл аймаг дах НҮБХХ-ийн төслийн зохицуулагч

Дорнод аймаг:

1. П. Алтаннавч Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдийн Хөдөлгөөний салбар зөвлөлийн гишүүн
2. Д. Баярмаа Чөлөөт Нийгмийн Ажилтны Төвийн тэргүүн.
3. Т. Шинэцэцэг Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төвийн салбарын зохицуулагч

Говь-Алтай аймаг:

1. Л. Болормаа Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдийн Хөдөлгөөний салбар зөвлөлийн гишүүн
2. Г. Хандмаа Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдийн Хөдөлгөөний салбар зөвлөлийн гишүүн
3. Л. Мөнхсүлд Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдийн Хөдөлгөөний салбар зөвлөлийн ажилтан

Отгонтэнгэр Их Сургуулийн Хууль Зүйн Сургууль:

1. С.Алтантуяа
2. Б.Алтантулга
3. Л.Баасансүрэн
4. Б.Батбилэг
5. Э.Баттулга
6. Ш.Давааням
7. Х. Сарангоо
8. П.Энхтуул
9. Ц.Эрдэнэбат
10. Х.Эрдэнэбаяр

Шихихутуг Хууль Зүйн Дээд Сургууль: Монгол Улсын Их Сургуулийн Хууль Зүйн Сургууль:

- | | |
|-------------------|-------------------|
| 1. Ш.Алимаа | 1. Б.Алтан-Од |
| 2. Ц.Амарсанаа | 2. Г.Батдолгор |
| 3. Г.Бат-Ирээдүй | 3. Э.Баярмаа |
| 4. С.Билгүүн | 4. Б.Бурмаа |
| 5. Э.Долгор | 5. О.Гэрлээ |
| 6. Б.Дүүрэнбаяр | 6. Н.Дариймаа |
| 7. Л.Золзаяа | 7. Г.Нямсүрэн |
| 8. М.Түвшинжаргал | 8. Э.Халиунаа |
| 9. Т.Ууганбат | 9. Б.Цэрэндорж |
| 10. Г.Чинбат | 10. Б.Эрдэнэ-Очир |

Төслийн баг:

Төсөл хэрэгжүүлэгч:

Нээлттэй Нийгэм Форум

Арга зүйг хамтарч боловсруулсан:

Отгонтэнгэр Их Сургуулийн Хууль Зүйн Сургуулийн Хууль Зүйн Клиник Төв

Хамтарч ажилласан:

Монгол Улсын Их Сургуулийн Хууль Зүйн Сургуулийн Хууль Зүйн Клиник Төв,
Шихихутаг Хууль Зүйн Дээд Сургуулийн Хууль Зүйн Клиник Төв

Ажиглалтын хуваарилалт:

- ОТИС-ийн Хууль Зүйн Сургууль нь Баянзүрх дүүргийн шүүх, Хан-Уул дүүргийн шүүх, Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүхэд;
- МУИС-ийн Хууль Зүйн Сургууль нь Баянгол дүүргийн шүүх, Чингэлтэй дүүргийн шүүх, Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүхэд;
- Шихихутаг Хууль Зүйн Дээд Сургууль нь Сүхбаатар дүүргийн шүүх, Сонгинохайрхан дүүргийн шүүх, Дорнод аймаг дахь Сум дундын шүүхэд тус тус ажиглалт хийсэн болно.

